# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 47 (332)

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай*
- *Усан замын тээврийн тухай*

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2004 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай*

**Улсын Их Хурлын Тамгын газар**
**Улаанбаатар хот**
**2003 он**

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2003 оны арванхоёрдугаар сарын 17 № 47 (332)

## Гарчиг

**Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

599. Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай (2003-11-28-ны хууль) 1033

600. Усан замын тээврийн тухай (2003-11-28-ны хууль) 1039

601. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль (2003-11-28-ны хууль) 1043

602. Автотээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай (2003-11-28-ны хууль) 1043

**Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

603. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2004 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай Дугаар 50 1043

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

## АХУЙН БОЛОН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### Нийтлэг үндэслэл

#### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, булах болон түүхий эдийн эх үүсвэр болгон дахин ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### 2 дугаар зүйл. Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хууль тогтоомж

2.1. Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль, Ариун цэврийн тухай хууль болон энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

#### 3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдал" /цаашид "хог хаягдал" гэх/ гэж хэрэглээний болон үйлдвэрлэл, үйлчилгээний явцад үүсч, цаашид тухайн зориулалтаар хэрэглэгдэхгүй болсон эд юмсыг;

3.1.2."аюултай хог хаягдал" гэж хүн, мал, амьтан, ургамлыг өвчлүүлэх, тэдгээрт хор хөнөөл учруулах, үр удамд нь сөргөөр нөлөөлөх, байгаль орчны тэнцлийг алдагдуулахад хүргэх шатах, тэсрэх, хордуулах, түлэх, халдварлах, эрчимтэй урвалжих шинж чанар бүхий бодисыг агуулсан хог хаягдлыг;

3.1.3."хог хаягдал булах" гэж ашиглах шаардлагагүй болсон хог хаягдлыг хүрээлэн байгаа орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх зорилгоор аюулгүй орчинд далдлан булахыг;

3.1.4."хог хаягдал хадгалах" гэж хог хаягдлыг булах, хоргүйжүүлэх, ашиглах зорилгоор хог хаягдал хадгалах зориулалтын цэгт түр хадгалахыг;

3.1.5."хог хаягдлыг ашиглах" гэж хог хаягдлыг бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил, үйлчилгээ явуулах, эрчим хүч гарган авах зэргээр дахин хэрэглээнд оруулахыг;

3.1.6."хог хаягдлыг аюулгүйжүүлэх" гэж хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах зорилгоор тусгай зориулалтын төхөөрөмжид шатаах, цэвэршүүлэх, халдваргүйжүүлэх, хоргүйжүүлэх зэргээр боловсруулахыг;

3.1.7."хог хаягдлын норматив" гэж нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд үүсэх тухайн төрлийн хаягдлын тогтоосон хэм хэмжээг;

3.1.8."хог хаягдал булах зориулалтын байгууламж" гэж хог хаягдлыг аюулгүй, хортой нөлөөлөлгүй хадгалах стандартын нөхцөлийг бүрдүүлсэн технологийн барилга, байгууламжийг;

3.1.9."хог хаягдал хадгалах цэг" гэж хог хаягдал цуглуулах зорилгоор байгуулсан зориулалтын сав, байгууламжийг;

3.1.10."хог хаягдлыг булах даац" гэж хог хаягдал булах зориулалтын байгууламжид тодорхой арга хэлбэрээр, тогтоосон хугацаанд, тухайн нутаг дэвсгэрийн экологийн төлөв байдлыг харгалзан булж болох тодорхой төрлийн хог хаягдлын зөвшөөрөхүйц дээд хэмжээг;

3.1.11 "аюултай хог хаягдлын паспорт" гэж хог хаягдлын бүтцийн талаархи мэдээллийг агуулсан, ямар төрөл аюулын зэрэглэлтэй хог хаягдалд хамаарахыг тогтоосон, түүнийг тээвэрлэх, хадгалах, устгах технологийг тусгасан эрх бүхий байгууллагаас олгосон баримт бичгийг.

**4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ**

4.1.Энэ хуулиар агаар мандал, усан орчны болон цацраг идэвхит хог хаягдлаас бусад хог хаягдалтай холбогдсон харилцааг зохицуулна.

**5 дугаар зүйл. Хог хаягдлын өмчлөх эрх**

5.1.Хог хаягдлыг үүсгэсэн этгээд түүнийг өмчлөх эрхтэй.

5.2.Бусдын өмчлөлд хөрөнгө шилжүүлэхтэй холбогдсон гэрээний үндсэн дээр хог хаягдлыг өмчлөх эрх шилжиж болно.

5.3.Энэ хуульд заасны дагуу хог хаягдлыг хаяснаар хог хаягдлыг өмчлөх тухайн этгээдийн эрх дуусгавар болж, хог хаягдлыг булах үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөх эрх үүснэ.

5.4.Аюултай хог хаягдлыг өмчлөгч нь өмчлөх эрхээ шилжүүлсэн бол энэ тухайгаа байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэж, аюултай хог хаягдлын улсын бүртгэлд бүртгүүлнэ.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нийтлэг эрх, үүрэг

**6 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх**

6.1.Улсын Их Хурал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.хог хаягдлын талаар баримтлах төрийн бодлогыг тодорхойлох;

6.1.2.хуульд заасан бусад бүрэн эрх.

**7 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх**

7.1.Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.хог хаягдлын талаархи төрийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах;

7.1.2.хог хаягдал гаргасны төлбөр тооцох болон хог хаягдлын норматив тогтоох аргачлалыг батлах;

7.1.3.хуульд заасан бусад бүрэн эрх.

**8 дугаар зүйл. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

8.1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1.хог хаягдлын талаархи төрийн бодлого, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах;

8.1.2.аюултай хог хаягдлын улсын тоо бүртгэлийг хөтлөх;

8.1.3.хог хаягдлын улсын тоо бүртгэл хөтлөх, тайлагнах журмыг батлах;

8.1.4.хог хаягдал булах зориулалтын байгууламж, төвлөрсөн цэгийн төрөл, тэдгээрт тавигдах шаардлага, хог хаягдал булах үйл ажиллагаа эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны журмыг батлах;

8.1.5.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

**9 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрх**

9.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1.хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

9.1.2.Засгийн газраас тогтоосон аргачлалын дагуу тухайн нутаг дэвсгэрт мөрдөх хог хаягдлын нормативыг тогтоох;

9.1.3.хог хаягдлыг бууруулахад чиглэсэн орон нутгийн хөтөлбөрийг батлах, түүний биелэлтэд дүгнэлт өгөх;

9.1.4.хуульд заасан бусад бүрэн эрх.

9.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга дараахь нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.2.1.хог хаягдлын талаархи төрийн бодлогын хэрэгжилтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулан хангах;

9.2.2.хог хаягдлыг бууруулахад чиглэсэн орон нутгийн чанартай хөтөлбөр боловсруулан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан, биелэлтийг нь хангах;

9.2.3.батлагдсан журмын дагуу нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хог хаягдлын улсын тоо бүртгэл хөтлөх;

9.2.4.хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, булах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг үнэлэх, санхүүжүүлэх журам болон сум, дүүргийн Засаг даргатай байгуулах гэрээний загвар батлах;

9.2.5. хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт, хийх шалгалтыг орон нутагтаа зохион байгуулах;

9.2.6. аймгийн төвийн сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу хог хаягдлын төвлөрсөн цэгийн байршлыг тогтоох;

9.2.7.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

9.3.Нийслэлийн Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.3.1.нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу хог хаягдлын төвлөрсөн цэгийн байршлыг тогтоох;

9.3.2.байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу хог хаягдал булах үйл ажиллагаа эрхлэх _аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулах;

9.3.3. хуульд заасан бусад бүрэн эрх.

9.4. Сумын Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.4.1.сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу сумын төвийн хог хаягдлын төвлөрсөн цэг болон хог хаягдал хадгалах түр цэгийн байршлыг тогтоох;

9.4.2.байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан журмын дагуу хог хаягдал булах үйл ажиллагаа эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулах;

9.4.3.хог хаягдал цуглуулах, тээвэрлэх иргэн , аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулах, батлагдсан загварын дагуу гэрээ байгуулан ажиллах, гэрээний биелэлтийг хариуцан тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын гэрээгээр гүйцэтгэсэн ажил, үйлчилгээг санхүүжүүлэх;

9.4.4.хот,тосгон, бусад суурингийн бус нутаг дэвсгэрт оршин сууж байгаа иргэдийн хог хаягдал булах аргачлалыг батлах;

9.4.5. нийтийн эдэлбэрийн газрын хог хаягдлыг цэвэрлүүлэх;

9.4.6. хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

9.4.7.хуульд заасан бусад бүрэн эрх.

9.5.Дүүргийн Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.5.1. хог хаягдал хадгалах түр цэгийн байршлыг тогтоох;

9.5.2.хог хаягдал цуглуулах, тээвэрлэх аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулах, батлагдсан загварын дагуу гэрээ байгуулан ажиллах, гэрээний биелэлтийг хариуцан тухайн аж ахуйн нэгж, байгууллагыг санхүүжүүлэх;

9.5.3. нийтийн эдэлбэрийн газрын хог хаягдлыг цэвэрлүүлэх;

9.5.4.хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

9.5.5.хуульд заасан бусад бүрэн эрх.

9.6.Баг, хорооны Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.6.1.нутаг дэвсгэрт байгаа хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах ажилд иргэдийг татан оролцуулах;

9.6.2.хог хаягдлын төлбөрийн барагдуулалтад хяналт тавих;

9.6.3.иргэд, аж ахуйн нэгж, байгууллага хог хаягдлаа зориулалтын цэгт хаяж байгаа байдалд хяналт тавих;

9.6.4. төв суурингаас алслагдсан хэсэг, бүлэг айл, өрх, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдал хадгалах түр цэгийг тогтоож мөрдүүлэх.

**10 дугаар зүйл. Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нийтлэг эрх, үүрэг.**

10.1.Иргэн дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

10.1.1.үүсгэсэн аюултай хог хаягдал, түүний эх үүсвэрийн талаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагад мэдээлж байх;

10.1.2.хуульд заасны дагуу хог хаягдал гаргасны төлбөрийг хугацаанд нь бүрэн төлөх;

10.1.3. зориулалтын цэгээс бусад газарт хог хаягдал хаяхгүй байх;

10.1.4.үүсгэсэн хог хаягдлаа хог хаягдал хадгалах түр цэгт ангилан хаях;

10.1.5.энэ хуульд заасан журмын дагуу олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх, хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг эрх бүхий этгээдээс шаардах;

10.1.6. хуульд заасан бусад эрх, үүрэг.

10.2.Аж ахуйн нэгж, байгууллага дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

10.2.1. явуулж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээний төрлөөс хамаарч хог хаягдлыг төрөлжүүлж, хог хаягдал хадгалах түр цэгт ангилан хаях, үйлдвэрлэлийн хог хаягдлын талаархи мэдээллийг төрийн болон нутгийн захиргааны байгууллагад үнэн зөв мэдээлэх;

10.2.2. хог хаягдлын талаархи дүрэм, журам, стандартын шаардлагыг хангаж ажиллах;

10.2.3.хог хаягдал гаргасны төлбөрийг хугацаанд нь бүрэн төлөх;

10.2.4. хог хаягдлын талаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах;

10.2.5. хог хаягдлыг ангилан хаях талаар зохих мэдлэгийг ажилтандаа эзэмшүүлж, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллах;

10.2.6.хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан биелэлтийг хангах;

10.2.7. хуульд заасан бусад эрх, үүрэг.

10.3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага орчны газрынхаа хог хаягдлыг цэвэрлэх болон хог хаягдлыг зайлуулах олон нийтийг хамарсан ажилд оролцох үүрэгтэй.

10.4.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн эзэмшил өмчлөлийн барилгаа барих, буулгах, засварлах тохиолдолд гарах хог хаягдлыг хаях талаар урьдчилан гэрээ байгуулан зохих төлбөрийг төлсний үндсэн дээр хог хаягдлыг хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, булах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлнэ.

10.5. Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, булах эрх аваагүй иргэн, аж ахуйн нэгж , байгууллага эдгээр үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Хог хаягдлыг хаях , цуглуулах , тээвэрлэх , булах , ашиглах

**11 дүгээр зүйл. Хог хаягдал хаях, булах**

11.1.Хот, тосгон, бусад суурин газарт оршин сууж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараахь журмаар хог хаягдлаа хаяна:

11.1.1.хог хаягдал хадгалах зориулалтын байгууламж бүхий орон сууцанд оршин суугч нь тухайн байгууламжид;

11.1.2.гэр хорооллын болон хог хаягдал хадгалах зориулалтын байгууламжгүй орон сууцанд оршин суугч иргэн, энэ хуулийн 11.3-т зааснаас бусад аж ахуйн нэгж, байгууллага хог хаягдлаа сум, дүүргийн Засаг даргын тогтоосон хог хаягдал хадгалах түр цэгт тогтоосон хугацаанд .

11.2.Хот, тосгон, бусад суурингийн бус нутаг дэвсгэрт оршин сууж байгаа иргэн ахуйн хэрэглээнээс нь үүссэн хог хаягдлаа сумын Засаг даргын баталсан аргачлалын дагуу булна.

11.3.Үндсэн үйл ажиллагаанаас нь тусгай ангиллын хог хаягдал их хэмжээгээр үүсгэдэг үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага стандартын шаардлага хангасан хог хаягдал булах зориулалтын байгууламжид үйлдвэрлэлийн хог хаягдлаа булна.

11.4. Энэ хуулийн 11.3-т заасан үйлдвэрлэлийн жагсаалтыг Засгийн газар батална.

11.5. Энэ хуулийн 11.1-т заасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хог хаягдал хадгалах түр цэгт хаях боломжгүй овор, даац ихтэй хог хаягдлаа хог хаягдал булах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай тохиролцон тэдгээрт шилжүүлж болно.

**12 дугаар зүйл. Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх**

12.1.Нийслэл, сумын Засаг дарга хот, тосгон, бусад суурины хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаа сонгон шалгаруулалтад шалгарч, гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаар гүйцэтгүүлнэ.

12.2.Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэхэд дараахь шаардлагыг тавина:

12.2.1.тогтоосон чиглэлийн дагуу хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэн, хог хаягдлын төвлөрсөн цэгт хүргэх;

12.2.2.хог хаягдлыг тээвэрлэх аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан битүүмжилсэн, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэх;

12.2.3.хууль тогтоомж, гэрээнд заасан бусад шаардлага.

12.3.Хог хаягдал тээвэрлэх чиглэлийг нийслэл, сумын Засаг дарга тогтооно.

12.4.Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдал булах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан ажиллах бөгөөд уг гэрээний биелэлтэд сум, дүүргийн Засаг дарга хяналт тавина.

**13 дугаар зүйл. Хог хаягдал булах**

13.1.Хог хаягдлын төвлөрсөн цэгийн хог хаягдал булах ажлыг эрх бүхий мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж болон тусгайлан эрх авсан иргэн эрхлэн гүйцэтгэнэ.

13.2.Хог хаягдал булах үйл ажиллагаа эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллага сум, дүүргийн Засаг даргатай гэрээ байгуулж ажиллана.

13.3.Энэ хуулийн 11.3-т заасан аж ахуйн нэгж, байгууллага хог хаягдлаа мэргэжлийн байгууллагын хяналтан дор тогтоосон газар булна. Хог хаягдлыг булах технологийн шаардлагыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

13.4.Хог хаягдлын төвлөрсөн цэг, хог хаягдал хадгалах түр цэгийн болон энэ хуулийн 11.3-т заасан аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдал булах зориулалтын байгууламжийн даацыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

**14 дүгээр зүйл. Хог хаягдлыг ашиглах**

14.1.Хог хаягдал булах үйл ажиллагаа эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хог хаягдлын түр болон төвлөрсөн цэгийн хог хаягдлыг ашиглах эрхтэй.

14.2.Аюултай хог хаягдлыг ашиглах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

**15 дугаар зүйл. Хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулахыг хориглох газар**

15.1. Хүн амын төвлөрсөн суурьшлын бүс, усны эрүүл ахуйн болон хамгаалалтын бүс, уурхайн эдэлбэр болон ашигт малтмалын нөөц нь тогтоогдсон болон бусад хууль тогтоомжоор хориглосон газарт хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулахыг хориглоно.

**16 дугаар зүйл. Аюултай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, булахад тавигдах нэмэлт шаардлага**

16.1.Хүрээлэн байгаа орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх хортой нөлөөллийн хэмжээнээс хамааруулан аюултай хог хаягдлын ангилал, ээрэглэлийг эрүүл мэнд, шинжлэх ухааны болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

16.2.Аюултай хог хаягдлыг паспортжуулах журмыг Засгийн газар батална.

16.3.Аюултай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, булахад аюулгүй байдлыг хангах шаардлагыг Засгийн газар тогтооно.

16.4.Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, импортлох, экспортлохтой холбогдсон харилцааг хуулиар зохицуулна.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

## Хог хаягдлын мэдээллийн сан

**17 дугаар зүйл. Хог хаягдлын мэдээллийн нэгдсэн сан**

17.1.Аймаг, нийслэл, сум, дүүрэг хог хаягдлын мэдээллийн сантай байна.

17.2.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өмчилж байгаа хог хаягдлын талаар тайлан, мэдээ гаргаж, тогтоосон хугацаанд баг, хорооны Засаг даргад хүргүүлж байна.

17.3.Энэ хуулийн 17.1 дэх хэсэгт заасан сан бүрдүүлэх, энэ талаархи мэдээллээр бусдад үйлчлэх журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## ТАВДУГААР БҮЛЭГ

## Хог хаягдлын эдийн засгийн зохицуулалт

**18 дугаар зүйл. Хог хаягдлын эдийн засгийн зохицуулалтын үндсэн зарчим**

18.1.Хог хаягдлын эдийн засгийн зохицуулалтад дараахь үндсэн зарчмыг баримтална:

18.1.1.хог хаягдлыг бууруулах, ашиглах;

18.1.2.хог хаягдал гаргасны төлбөр төлөх;

18.1.3.хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, булах үйл ажиллагаанд оролцогчдод эдийн засгийн урамшуулал үзүүлэх;

18.1.4.импортоор оруулсан дахин ашиглагдах боломжгүй бараа материал, хог хаягдлын төлбөрийг тусгай хуулиар зохицуулах.

**19 дүгээр зүйл. Хог хаягдлын эдийн**

засгийн зохицуулалтыг боловсронгуй болгох хөтөлбөрүүд

19.1.Хог хаягдлыг бууруулах, ашиглах, булах үйл ажиллагааг хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчны төлөв байдал болон газар нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшинтэй уялдуулан төлөвлөх үүднээс төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагууд хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, булах үйл ажиллагааг боловсронгуй болгох улс, бүс, орон нутгийн хөгжлийн хөтөлбөрүүдийг боловсруулна.

**20 дугаар зүйл. Хог хаягдал гаргасны төлбөр**

20.1.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн хог хаягдал гаргасны төлбөр төлнө.

20.2.Хог хаягдал гаргасны төлбөрийн хэмжээг Засгийн газраас баталсан аргачлалын дагуу аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

20.3.Хог хаягдал гаргасны төлбөрийн орлогыг нийслэл, сумын хаягдлын үйлчилгээний санд төвлөрүүлнэ.

**21 дүгээр зүйл. Хог хаягдлын үйлчилгээний сан**

21.1.Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, булах үйл ажиллагааг санхүүжүүлэх бие даасан эх үүсвэрийг бий болгох, хог хаягдлыг багасгах үйл ажиллагааг дэмжих зорилгоор нийслэл, сумын Засаг дарга хог хаягдлын үйлчилгээний сан байгуулан ажиллуулна.

21.2.Хог хаягдлын үйлчилгээний сангийн хөрөнгө нь нийслэл, сумын төсвийн бүрэлдэхүүн хэсэг болох бөгөөд түүнийг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, гүйцэтгэлийн тайлан, мэдээ гаргах ажиллагааг тухайн төсвийн нэгэн адил журмаар хэрэгжүүлнэ.

21.3.Хог хаягдлын үйлчилгээний сангийн орлого нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

21.3.1.хог хаягдал гаргасны төлбөрийн орлого;

21.3.2.зээл, тусламж, хандивын орлого;

21.3.3.нийтийн эдэлбэрийн газрын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, булах зориулалтаар орон нутгийн төсвөөс зарцуулах хөрөнгө;

21.3.4.бусад.

21.4.Хог хаягдлын үйлчилгээний сангийн хөрөнгийг дараах зориулалтаар зарцуулна:

21.4.1.хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, булах;

21.4.2.хог хаягдлыг багасгах үйл ажиллагааг дэмжих;

21.4.3.хог хаягдлын төвлөрсөн цэгийг нөхөн сэргээх;

21.4.4.хүн амд мэдээлэл, сургалт,сурталчилгаа явуулах.

**ЗУРГАДУГААР БҮЛЭГ**

**Хог хаягдлын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналт ,хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага**

**22 дугаар зүйл. Хог хаягдлын тухай хууль тогтоомжид тавих хяналт**

22.1.Хог хаягдлын тухай хууль тогтоомжийн биелэлтэд эрх бүхий мэргэжлийн хяналтын байгууллага, бүх шатны Засаг дарга хяналт тавина.

22.2. Сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга нутаг дэвсгэртээ хог хаягдлын тухай хууль тогтоомжоор тогтоосон захиргааны үүргийн биелэлтэд хяналт тавих олон нийтийн байцаагч ажиллуулж болно. Олон нийтийн байцаагч ажиллуулах, тэдгээрт мөнгөн урамшуулал олгох асуудлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12, 13 дугаар зүйлийн дагуу зохицуулна.

22.3. Хог хаягдлын байгууламжийн байршил нь хот төлөвлөлт, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй, хог хаягдлыг булах технологи, үйл ажиллагаа нь хүрээлэн байгаа орчин, хүний эрүүл мэндэд халтай, эсхүл хууль тогтоомжид нийцээгүй бол мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага уг байгууламжийн үйл ажиллагааг зогсоож, учирсан хохирлыг буруутай этгээдээр төлүүлнэ.

22.4.Хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол улсын байцаагч болон сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга дараахь хариуцлага хүлээлгэнэ:

22.4.1.зориулалтын бус газар хог хаягдал хаясан иргэнийг 1000-15000 хүртэл төгрөгөөр, аж ахуйн нэгж байгууллагыг 150000-200000 хүртэл төгрөгөөр торгож, учруулсан хохирлыг арилгуулах;

22.4.2.энэ хуулийн 14.1-ийг зөрчсөн иргэнийг 30000-50000 хүртэл, аж ахуйн нэгж байгууллагыг 150000-250000 хүртэл төгрөгөөр торгох;

22.4.3.хог хаягдал хадгалах зориулалтын бус газар болон нийтийн эдэлбэрийн газарт нийлэг уут, сав, бохь, тамхины иш хаясан иргэнийг 1000-10000 төгрөгөөр торгох.

**23 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

23.1.Энэ хуулийг 2004 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

## УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### Нийтлэг үндэслэл

**1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

1.1.Энэхүү хуулийн зорилт нь усан замын тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх үйл ажиллагаа болон усан замын тээврийн хэрэгсэлд тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлох, усан замын тээврийн хэрэгслийг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хуульд өөрөөр заагаагүй бол усан замын тусгай зориулалтын тээврийн хэрэгслийг нийтийн зориулалтаар ашиглахад энэ хуулийн дагуу зохицуулна.

**2 дугаар зүйл. Усан замын тээврийн тухай хууль тогтоомж**

2.1.Усан замын тээврийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд заасныас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2.3.Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаад улсын хуулийн этгээд, иргэн усан замын тээврийн хэрэгслээр тээвэрлэлт гүйцэтгэхэд Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол тус улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо**

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "усан зам" гэж усан замын тээврийн хэрэгслийг аюулгүйгээр зорчиход зориулагдсан хөвөлтийн болон бусад дохио, тэмдэг бүхий усан зурвасыг;

3.1.2."усан замын тээвэр" гэж гол мөрөн, нуурын усанд усан замын тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэлтийг;

3.1.3."усан замын тээврийн хэрэгсэл" гэж усан замаар зорчигч, ачаа тээвэрлэхэд зориулсан бүх төрлийн усан онгоц, чирэгч онгоц, чиргүүл онгоц, шумбагч онгоц, завь, бярвааз, хөвөгч төхөөрөмж, хөвөгч байгууламжийг;

3.1.4."усан замын тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл" гэж цэрэг, цагдаа, хил хамгаалах, гаалийн болон төрийн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагын усан замын тээврийн хэрэгслийг;

3.1.5."усан замын тээврийн хэрэгсэл эзэмшигч /цаашид "эзэмшигч" гэх/" гэж усан замын тээврийн хэрэгслийг хууль ёсоор эзэмшиж, ачаа, зорчигч тээвэрлэхэд ашиглаж байгаа этгээдийг;

3.1.6."зорчигч" гэж усан замын тээврийн хэрэгсэл дээр буюу тавцан дээр зорчиж байгаа хүнийг;

3.1.7."ачаа" гэж усан замын тээврийн хэрэгслээр тээвэрлэж байгаа эд зүйлсийг;

3.1.8."тээвэрлэлт" гэж усан замын тээврийн хэрэгслээр зорчигч болон ачааг усан замын нэг зогсоолоос нөгөө зогсоолд шилжүүлэн зөөхтэй холбогдсон ажил, үйлчилгээг;

3.1.9."тээвэрлэгч" гэж усан замын тээвэрлэлтийн ажил, үйлчилгээ эрхэлж байгаа этгээдийг;

3.1.10."тээвэрлүүлэгч" гэж усан замын тээвэрлэлтийн үйлчилгээ хэрэглэгчийг;

3.1.11."зогсоол" гэж зорчигчдыг буулгах, суулгах, ачаа ачих, буулгахад зориулагдсан гэрэлтүүлэг, аврах хэрэгсэл зэргээр бүрэн хангагдсан эрэг дээрх байгууламжийг;

3.1.12."тээврийн баримт бичиг" гэж зорчигч, ачаа ачсан, хүлээн авсан тухай тэмдэглэгээ хийж, баталгаажуулсан баримтыг.

### ХОЁРДУГААР БҮЛЭГ

### Усан замын тээврийн талаархи төрийн байгууллагын бүрэн эрх

**4 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх**

4.1.Монгол Улсын Их Хурал усан замын тээврийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.1.1.усан замын тээврийн талаар төрөөс баримтлах бодлого тодорхойлох;

4.1.2. олон улсын усан замын тээврийн холбогдолтой гэрээ соёрхон батлах;

4.1.3. усан замын тээврийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах.

[1] Монгол Улсын Үндсэн хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

**5 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх**

5.1.Засгийн газар усан замын тээврийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1.усан замын тээврийн талаар төрөөс баримтлах бодлого хэрэгжүүлэх ;

5.1.2. усан замын тээврийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангах;

5.1.3. усан замын тээврийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг хэрэгжүүлэх, усан замын тээврийн улсын хяналтын дүрмийг батлах.

**6 дугаар зүйл. Усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

6.1.Усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.усан замын тээврийн талаар төрөөс баримтлах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх;

6.1.2. усан замын тээврийн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

6.1.3. усан замын тээврийн үйлчилгээ болон усан замын дохио, тэмдгийн угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох. Тусгай зөвшөөрөл олгох журмыг батлах;

6.1.4. усан замын сүлжээн дэх олон улсын болон улсын чанартай замын чиглэлийг батлах;

6.1.5. тээвэрлэлтийн үйл ажиллагаа, усан замын тээврийн хэрэгсэл, усан замын байгууламжийн техник ашиглалтын талаар нийтлэг мөрдөх дүрэм, журам, норм, нормативыг батлах, тэдгээрийн биелэлтийг хангуулах;

6.1.6. усан замын тээврийн асуудлаар олон улсын үйл ажиллагаанд оролцох, улс хооронд тээвэрлэх ачаа, зорчигчдын хэмжээ болон тээвэрлэлтийн аюулгүй байдал, үйлчилгээний чанарын шаардлагын талаар холбогдох улстай тохиролцох;

6.1.7. усан замын зорчигч, ачаа тээвэрлэлтийн үнэ, тарифын аргачлалыг боловсруулах.

**7 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх**

7.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга усан замын тээврийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.усан замын тээврийн талаар төрөөс баримтлах бодлоготой уялдуулан тухайн нутаг дэвсгэрт усан замын тээврийг зохицуулах асуудлыг төрийн захиргааны төв байгууллагатай хамтран шийдвэрлэх, хэрэгжилтийг зохион байгуулах;

7.1.2. нутаг дэвсгэртээ усан замын тээврийн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах;

7.1.3. усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон улсын мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран нутаг дэвсгэртээ усан замын тээврийн улсын хяналт хэрэгжүүлэх;

7.1.4. усан замын тээвэрлэлтийн чиглэлийг тогтоох, өөрчлөх шийдвэрийг усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран шийдвэрлэх;

7.1.5. тухайн нутаг дахь усан замын болон зогсоолын дохио, тэмдгийн засвар, арчлалт, хамгаалалт, ашиглалтад хяналт тавих;

7.1.6. усан замын зогсоолын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг зохицуулах.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ**

**Усан замын тээврийн хэрэгслийн бүртгэл, тусгай зөвшөөрөл**

**8 дугаар зүйл. Тээврийн хэрэгслийн бүртгэл**

8.1.Усан замын тээврийн хэрэгслийг энэ хуулийн 14.3-д заасан журмын дагуу бүртгэнэ.

8.2. Усан замын тээврийн хэрэгслийг эзэмшигч нь усан тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлж, бүртгэлийн гэрчилгээ авна. Гэрчилгээнд тээврийн хэрэгслийн марк, нэр, дугаар, үйлдвэрлэгдсэн он, эзэмшигчийн нэр зэргийг тэмдэглэсэн байна.

8.3.Усан замын тээврийн хэрэгслийн дугаарыг усан тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгоно.

8.4.Усан замын тээврийн хэрэгслийн нэр буюу дугаарыг тээврийн хэрэгслийн үзгэдэх хэсэгт дэвсгэр өнгөнөөс тодоор ялгагдах өнгөөр тэмдэглэнэ.

8.5. Улсын бүртгэлд бүртгэгдсэн усан онгоцон дээр Монгол Улсын Төрийн далбааг мандуулна.

**9 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл**

9.1. Усан замын нийтийн тээврийн үйлчилгээ болон усан замын дохио, тэмдгийн угсралт, засвар үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, иргэнд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай[2] хуулийн дагуу тусгай зөвшөөрөл олгоно.

9.2. Тусгай зөвшөөрөл авахад аж ахуйн нэгж, иргэн дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

9.2.1. ажил, үйлчилгээг гүйцэтгэх мэргэжлийн боловсон хүчин, усан замын тээврийн хэрэгслийн бичиг баримтын бүрдэл, усан замын тогтоосон чиглэл, аюулгүй ажиллагааны шаардлага;

9.2.2. тухайн ажил, үйлчилгээнд мөрдүүлэхээр эрх бүхий байгууллагаас баталсан стандарт, дүрэм, журмаар тогтоосон нөхцөл.

9.3. Энэ хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, иргэнтэй гэрээ байгуулж ажиллана.

9.4. Усан замын тээврийн ажил, үйлчилгээ эрхлэхээр хэд хэдэн сонирхогч этгээд өргөдөл гаргасан тохиолдолд уг ажил, үйлчилгээний эрэлт, хэрэгцээг харгалзан сонирхогчдыг сонгон шалгаруулах замаар тусгай зөвшөөрөл олгож болно.

**10 дугаар зүйл. Усан замын тээврийн хэрэгсэлд тавигдах техникийн шаардлага**

10.1.Усан замын тээврийн хэрэгсэлд тавигдах техникийн шаардлагыг усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

10.2. Энэ хуулийн 10.1-д заасан техникийн шаардлага нь усан замын тусгай зориулалтын тээврийн хэрэгсэлд нэгэн адил хамаарна.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**

**Усан замын тээвэрлэлт**

**11 дүгээр зүйл. Тээвэрлэлт гүйцэтгэх**

11.1.Усан замын тээвэрлэлтийг Иргэний хууль[3] болон энэ хуульд нийцсэн гэрээний дагуу гүйцэтгэнэ.

11.2.Усан замын тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрэм болон хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журмыг усан замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

**12 дугаар зүйл. Тээвэрлэгчийн эрх, үүрэг**

12.1.Тээвэрлэгч нь дараах эрх эдэлнэ:

12.1.1.зорчих тасалбарыг урьдчилан аваагүй буюу тээврийн хөлс төлөхгүй байгаа зорчигч, мөн тээвэрлэлтийн нөхцөлийн дагуу бэлтгээгүй ачааг тээвэрлэхээс татгалзах;

12.1.2.усан замын тээврийн хэрэгслийн ахмад, жолоодогч, түүний ажилтнууд зорчигчид нийгмийн хэв журмыг сахих, тээврийн үйлчилгээний дотоод дүрэм, журмыг биелүүлэх шаардлага тавих.

12.2.Тээвэрлэгч нь дараах үүрэг хүлээнэ:

12.2.1.өөрийн тээвэрлэлтийн үйлчилгээний талаархи үнэн зөв мэдээллээр тээвэрлүүлэгчийг хангах, зорчигчийн амь нас, эрүүл мэнд, ачаанд аюул, хохирол учруулахгүй байх;

12.2.2.тээвэрлэлтийн нөхцөл, техникийн шаардлага хангасан усан замын зориулалтын тээврийн хэрэгслээр зорчигчийг тав тухтай, аюул, осолгүй тээвэрлэх, аюул ослын үед зорчигчийг авран хамгаалах хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжөөр хангах;

12.2.3.ачаа, зорчигчийг усан замын урьдчилан тогтоосон чиглэл, цагийн хуваарийг баримтлан тээвэрлэх;

12.2.4.усан замын тээврийн хэрэгслийн эзэмшигч, ахмад, жолоодогч нь усан замын тээврийн хэрэгслийг гал түймрээс урьдчилан сэргийлэх, хэвлтийн аюулгүй байдлыг хангах, байгаль орчныг бохирдуулахаас сэргийлэх, иргэдийн эрүүл мэнд, амгалан тайван байдлыг алдагдуулахгүй байх нөхцөлийг хангасан зориулалтын зогсоолд байрлуулах;

12.2.5. усан замын тээвэрлэлтийн үед аюул, осол гарсан тохиолдолд тухайн орон нутаг дахь гамшгаас хамгаалах албанд шуурхай мэдэгдэх;

12.2.6.усан замын тээвэрлэлт эхлэх болон тээвэрлэлтийн үеийн ус цаг уур, орчны мэдээг орон нутгийн ус цаг уур, орчны хяналт шинжилгээний байгууллагаас тогтмол авч байх;

12.2.7.усан зогсоолыг стандартын дагуу тоноглох, төхөөрөмжлөх, арчлан хамгаалах, ашиглах;

---

[2] Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2001 оны 6 дугаарт нийтлэгдсэн
[3] Иргэний хууль -"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

12.2.8.усан замын тээврийн хэрэгсэл дээр ажиллах мэргэжлийн боловсон хүчинтэй байх ба тэднийг сургаж бэлтгэх.

**13 дугаар зүйл. Зорчигч, тээвэрлүүлэгчийн эрх, үүрэг**

13.1.Зорчигч, тээвэрлүүлэгч нь дараахь эрх эдэлнэ:

13.1.1.тээвэрлэлтийн нөхцөл, техникийн шаардлага хангаагүй, усан замын зориулалтын бус тээврийн хэрэгслээр үйлчлүүлэхээс татгалзах;

13.1.2.усан замын тогтоосон чиглэл, гэрээгээр тохиролцсон хугацааг баримтлахыг тээвэрлэгчээс шаардах.

13.2. Зорчигч, тээвэрлүүлэгч нь дараахь үүрэг хүлээнэ:

13.2.1.ачааны савлалт, баглаа, боодол, бэхэлгээг стандартын дагуу хийж, нэр төрөл, илгээх чиглэлээр нь ялган тээвэрлэхэд бэлтгэх;

13.2.2.ачих, буулгах машин механизм, нэмэгдэл тоноглол, хүн хүчийг бэлэн байлгаж ачааг тогтоосон хугацаанд ачих, буулгах, өөрийн хаягтай буюу гэрээт ачааг хүлээн авах;

13.2.3.ачааг тээвэрлэх, хадгалах тухай мэдээллээр тээвэрлэгчийг хангах;

13.2.4.ачааг ачсан, хүлээн авсан тухайгаа тээврийн баримт бичигт тэмдэглэж баталгаажуулан тээвэрлэгчид олгох;

13.2.5.усан замын тээврийн хэрэгслээр зорчихдоо бусдын амь нас, эрүүл мэндэд аюул, гэм хор учруулж болзошгүй эд зүйлийг авч явахгүй байх;

13.2.6.усан тээврийн хэрэгслээр зорчихдоо тээврийн хэрэгслийг эвдэж, гэмтээхгүй байх.

**ТАВДУГААР БҮЛЭГ**

**Усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналт**

**14 дүгээр зүйл. Техникийн хяналт, тооллого**

14.1.Усан замын тээврийн хэрэгслийн хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд нөлөө үзүүлэх сөрөг хүчин зүйлсийн зөвшөөрөгдөх хэмжээний түвшин, тээвэрлэлтийн болон техник ашиглалтын шаардлагыг хангасан байдалд усан тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас гурван жил тутамд техникийн хяналтын үзлэг, тооллого хийж гэрчилгээ олгоно.

14.2.Техникийн хяналтын үзлэг, тооллого хийсэн гэрчилгээнд заасан хугацаанд техникийн хяналтын үзлэг, тооллогод ороогүй усан замын тээврийн хэрэгслийг усан замын тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.

14.3.Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн болон экологийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журмыг усан замын тээврийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

**ЗУРГАДУГААР БҮЛЭГ**

**Усан замын тээврийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих**

**15 дугаар зүйл. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд тавих мэргэжлийн хяналт**

15.1. Усан замын тээврийн тухай хууль тогтоомжийн биелэлт, усан замын тээврийн зохион байгуулалт, усан замын тээврийн хэрэгслийн техник ашиглалтын байдалд улсын мэргэжлийн хяналтын байгууллагын усан замын тээврийн улсын байцаагч хяналт тавина.

**ДОЛДУГААР БҮЛЭГ**

**Бусад зүйл**

**16 дугаар зүйл. Усан замын тээврийн тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага**

16.1. Усан замын тээврийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч, усан замын тээврийн хяналтын улсын байцаагч гэм буруутай этгээдэд дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

16.1.1.энэ хуулийн 12.2, 13.2.1, 13.2.2, 13.2.3, 13.2.4 дэх заалтыг зөрчсөн иргэнийг 5000-30000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-250000 төгрөгөөр торгох;

16.1.2.энэ хуулийн 13.2.5, 13.2.6 дахь заалтыг зөрчсөн иргэнийг 1000-5000 төгрөгөөр торгох;

16.1.3.энэ хуулийн дагуу эрх бүхий байгууллагаас гаргасан нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг зөрчсөн албан тушаалтныг 10000-60000 төгрөгөөр, иргэнийг 1000-30000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-150000 төгрөгөөр торгох;

16.1.4.усан замын тээврийн хэрэгслийг бүртгүүлж, гэрчилгээ авалгүйгээр тээвэрлэлт хийсэн бол уг тээврийн хэрэгслийн эзэмшигчид Захиргааны хариуцлагын тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

### АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

**1 дүгээр зүйл.** Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд дор дурдсан агуулгатай 15.8.21, 15.8.22 дахь заалтыг нэмсүгэй:

"15.8.21. усан замын тээврийн үйлчилгээ эрхлэх;

15.8.22.усан замын дохио, тэмдгийн угсралт, засвар үйлчилгээ эрхлэх."

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Усан замын тээврийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

### АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

**1 дүгээр зүйл.** Автотээврийн тухай хуульд дор дурдсан агуулгатай заалтыг нэмсүгэй:

1/ 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 12 дахь заалт:

"3.1.12. "мөсөн замын тээвэр" гэж гол, мөрөн, нуурын ус хөлдсөн үед мөсөн дээгүүр хийх тээвэрлэлтийг"

2/ 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт:

"7.1.6. орон нутгийн цаг уурын байдлыг харгалзан мөсөн замын тээвэрлэлтийг эхлэх, дуусах хугацаа, чиглэл, мөсний даацыг тухайн орон нутгийн ус цаг уур, орчны хяналт шинжилгээний байгууллагатай хамтран тогтоох."

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Усан замын тээврийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2003 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр

Дугаар 50

Улаанбаатар хот

### Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2004 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7, Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2004 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хавсралтаар батлагсугай.

2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2004 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилттэй уялдуулан оны эхнээс жигд биелүүлэх зохион байгуулалттай арга хэмжээ авч, хэрэгжилтийн явцыг хагас, бүтэн жилээр гаргаж, Улсын Их Хуралд танилцуулж байхыг Монгол Улсын Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ**

*Монгол Улсын Их Хурлын 2003 оны*
*50 дугаар тогтоолын хавсралт*

## МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2004 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

| Бодлогын зорилт | Бодлогын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Хэрэгжүүлэх эзэн |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

### НЭГ.МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭНД:

*Эдийн засаг, нийгмийн хөгжлийн таатай орчныг бүрдүүлэх, аж үйлдвэр, газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, мөнгө, санхүүгийн тогтвортой байдлыг бататгах бодлого явуулах замаар дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийг 2004 онд 6.0 хувьд хүргэнэ.*

| | | | |
|---|---|---|---|
| 1.Эдийн засгийн бодит өсөлтийг хангах орчныг сайжруулж, дэмжлэг үзүүлнэ. | -Эдийн засаг, нийгэм, төсвийн хүрээн дэх өөрчлөлтийг эрчимжүүлж, дотоодын үйлдвэрлэл, хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих, банк, санхүүгийн салбарын үйлчилгээг өргөжүүлэх, бүс нутаг, хөдөөгийн хөгжлийг хангах бодлого явуулах замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангана. | жилдээ | Ч.Улаан<br>О.Чулуунбат<br>Д.Насанжаргал<br>Ч.Ганзориг |
| | -Инфляцийг макро эдийн засгийн тогтворжилтыг бататгах, микро түвшинд үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх, бизнесийн тогтвортой орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтыг урамшуулах түвшинд байлгах бодлого явуулна. | жилдээ | О.Чулуунбат |
| | -Инфляцийн түвшинтэй уялдуулсан зээлийн бодит хүүг зөрэг түвшинд байлгахын зэрэгцээ нэрлсэн зээлийн хүүг бууруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ. | жилдээ | О.Чулуунбат |
| | -Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг хангахад дэмжлэг болохуйц хэмжээнд дэд бүтцийн салбарын хөгжлийг хангана. | жилдээ | Б.Жигжид |
| | -Бизнесийн үйл ажиллагааг цаашид идэвхжүүлэх, хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлнэ. | жилдээ | Б.Жигжид |

| | | | |
|---|---|---|---|
| | -Эдийн засгийг 2021 он хүртэл хөгжүүлэх Үндэсний хөгжлийн хөтөлбөрийг боловсруулна. | I-II улирал | Ч.Улаан<br>А.Цанжид |
| | -Далд эдийн засгийн нөхцөл байдлын талаар судалгаа явуулж, түүнийг арилгахад чиглэсэн арга хэмжээ авна. | III-IV улирал | Ч.Улаан<br>П.Бямбацэрэн |
| | -Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын ачааллыг багасгах асуудлыг судалж шийдвэрлэнэ. | I-II улирал | Ч.Улаан |
| 2.Эдийн засгийн өсөлтөд геологи, уул уурхайн салбараас оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ. | -Бороогийн алтны үндсэн, Тосонгийн Драгийн шороон ордыг ашиглах уулын үйлдвэрийн олборлолтыг төслийн хүчин чадалд нь хүргэж алт олборлолтын дүнг 15.0 тоннд хүргэнэ. | жилдээ | Ч.Ганзориг |
| | -Эрдэнэт үйлдвэрийн дэргэд исэлдсэн хүдрийг гидрометаллургийн аргаар боловсруулан жилд 10.0-15.0 мянган тонн цэвэр зэс гаргах үйлдвэрийг ашиглалтад оруулах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ. | жилдээ | Ч.Ганзориг |
| | -Төмөртийн Овооны цайрын ордыг түшиглүүлэн барих үйлдвэрийн дэд бүтэц, хайгуул, туршилтын ажлыг дуусгаж, ил уурхай, зарим барилга, байгууламжийн ажлыг эхлүүлнэ. | жилдээ | Ч.Ганзориг |
| | -Газрын тосны хайгуулын ажлыг эрчимжүүлж, олборлолтыг 240.0 мянган баррельд хүргэнэ. | жилдээ | Ч.Ганзориг |
| | -Асгатын мөнгөний ордыг ашиглахад шаардлагатай дэд бүтцийг бий болгох асуудлыг хамтын ажиллагааны хүрээнд шийдвэрлэх ажлыг эрчимжүүлнэ. | жилдээ | Ч.Ганзориг |
| | -Тавтын алтны ордыг ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ. | II улиралд | Ч.Ганзориг |
| 3.Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах хүрээнд эдийн засаг дахь мөнгөний эрэлтийг оновчтой удирдана. | -Эдийн засгийн өсөлтийг мөнгөний бодлогоор дэмжиж, мөнгөний нийт нийлүүлэлтийг зохистой түвшинд удирдаж, санхүүгийн зах зээлийг гүнзгийрүүлэн, төсөв, санхүүгийн оновчтой бодлого хэрэгжүүлнэ. | жилдээ | О.Чулуунбат<br>Ч.Улаан |
| | -Нэгдсэн төсвийн урсгал тэнцлийн ашгийн ДНБ-нд эзлэх хувийг 4.0-т хүргэнэ. | жилдээ | Ч.Улаан |

| | | | |
|---|---|---|---|
| 4.Улсын салбар дахь бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэн үр ашгийг дээшлүүлнэ. | -Зах зээлийн зарчимд нийцсэн мөнгөний бодлогын шууд бус арга хэрэгслийг ашиглан арилжааны банкуудын зээлийн хүүг үндэсний үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих бодлогын хүрээнд бууруулах бодлого баримтлахын хамт банкны системийг бэхжүүлэх, банкууд дахь Засгийн газрын өр, зээлийг бууруулж, төсвийн тэнцлийг сайжруулах арга хэмжээг харилцан уялдаатай хэрэгжүүлнэ. | жилдээ | О.Чулуунбат |
| | -Засгийн газрын бондын арилжааг үнэт цаасны зах зээл дээр явуулж, банкны бүтцийн өөрчлөлтийн бондыг хөрвөх чадвартай үнэт цаасаар арилжаалах асуудлыг судалж шийдвэрлэнэ. | жилдээ | Ч.Улаан<br>О.Чулуунбат |
| | -Банкуудад байршиж байгаа банкны бүтцийн өөрчлөлтийн бондыг үе шаттайгаар мөнгөжүүлнэ. | жилдээ | Ч.Улаан<br>О.Чулуунбат |
| | -Төрийн өмчийг 2004 онд хувьчлах хөтөлбөрийг батлуулан, хувьчлалыг эрчимжүүлж, улсын төсөвт 13.6 тэрбум төгрөгийг төвлөрүүлнэ. | жилдээ | Ө.Энхтүвшин |
| | -Үйлдвэр, аж ахуйн газрыг дуудлага худалдаагаар худалдах, гэрээгээр үе шаттай хувьчлах, удирдлагыг нь гэрээгээр ажиллуулах зэрэг олон аргуудаас оновчтой хэлбэрийг сонгож, хувьчлалыг эрчимжүүлнэ. | жилдээ | Ө.Энхтүвшин |
| | -Эдийн засгийн үр ашиг, үндэсний аюулгүй байдлыг хангах шаардлагад нийцүүлэн үнэ цэнэтэй томоохон аж ахуйн нэгжүүдийг хувьчилна. | жилдээ | Ө.Энхтүвшин |
| | -Цахилгаан холбооны салбарыг хувьчлах 2 дахь шатны хувьчлалын үзэл баримтлалыг эцэслэн боловсруулж, хувьчлах арга хэмжээг эхлүүлнэ. | II-III улирал | Ө.Энхтүвшин<br>Б.Жигжид |
| | -"Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарыг хувьчлах хөтөлбөр"-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, үлдсэн 6 аймаг, Улаанбаатар хотын нийтийн аж ахуйн үйлчилгээний болон ус суваг ашиглалтын байгууллагыг менежментийн гэрээгээр ажиллуулна. | жилдээ | Б.Жигжид<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | -Автозамын салбарын төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой зам, барилгын аж ахуйн нэгжүүдийн хувьчлалыг үргэлжлүүлж, авто замын засвар, арчлалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж, авто замын сүлжээний засвар, арчлалтын чанар, ашиглалтын түвшинг дээшлүүлнэ. | жилдээ | Ө.Энхтүвшин<br>Б.Жигжид |

| | | | |
|---|---|---|---|
| | -"Монгол Чехметалл" ХХК, "Монголын цахилгаан холбоо" ХК, Хөтөлийн цемент шохойн үйлдвэр, "Булигаар" ХК зэрэг томоохон аж ахуйн нэгжүүдийг хувьчилна. | жилдээ | Ө.Энхтүвшин<br>Б.Жигжид<br>Ч.Ганзориг |
| | -Эрчим хүчний хувьцаат компаниудын зах зээлд бие даан ажиллах чадварыг сайжруулж, дотоод хэрэглээ, шугамын болон зүй бусын алдагдлыг бууруулан үр ашгийг дээшлүүлж төсөвт тус салбараас үзүүлэх дарамтыг багасгаж, санхүүгийн чадварыг дээшлүүлнэ. | Жилдээ | Б.Жигжид |
| | -Өр, авлагыг шийдвэрлэх механизмыг боловсронгуй болгож, эрчим хүчний салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа цахилгаан станцууд, нүүрсний уурхай, түгээх сүлжээ, хэрэглэгчдийн хоорондын өр авлагыг барагдуулах арга хэмжээ авахын хамт цаашид шинэ өр үүсэх явдлыг зогсооно. | Жилдээ | Б.Жигжид |
| | -Төрийн албаны шинэчлэлийн хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлж эхлэнэ. | Жилдээ | Ж.Норовсамбуу<br>Ч.Улаан<br>Ш.Батбаяр |
| | -Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдах төслүүдийн үнэлгээний болон тендерийн эдийн засгийн шалгууруудыг тогтооно. | Жилдээ | Ч.Улаан |
| | -Монголбанкны тайлан тэнцлийг гаргахад олон улсын бүртгэлийн системийг хэрэглэж эхлэнэ. | жилдээ | О.Чулуунбат |
| 5.Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг дэмжинэ. | -Даатгал болон бусад сангуудын үлдэгдэл хөрөнгийг хөрөнгө оруулалтын зориулалтаар ашиглах эрх зүйн орчныг бий болгоно. | II-IV улирал | Ч.Улаан<br>Ш.Батбаяр |
| | -Нийгмийн даатгалын сангийн үлдэгдэл, хувийн хуримтлалыг үнэт цаасны зах зээл рүү татан оруулах арга хэрэгслийг бий болгоно. | жилдээ | С.Гүндэнбал<br>Ч.Улаан<br>Ш.Батбаяр |
| | -Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын банкинд итгэх итгэлийг дээшлүүлэх, санхүүгийн зуучлалын цар хүрээг өргөтгөх, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр хадгаламжийн даатгалын тогтолцоо, эрх зүйн орчныг бий болгох асуудлыг судлаж шийдвэрлэнэ. | I-II улирал | Ч.Улаан<br>О.Чулуунбат |

| | | | |
|---|---|---|---|
| | -Хоршоодод үйлчлэх банк, даатгалын сүлжээ бий болгох, хадгаламж, зээлийн хоршоо байгуулахад дэмжлэг туслалцаа үзүүлнэ. | жилдээ | Ч.Улаан<br>О.Чулуунбат |
| 6.Банк, санхүүгийн байгууллагын зуучлалын хүрээг өргөтгөнө. | -Хадгаламжийн банкны санхүү, төлбөрийн чадварыг дээшлүүлэх, бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөө боловсруулж, арилжааны хэлбэрт бүрэн шилжүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, улмаар 2004 онд хувьчлах бэлтгэлийг хангана. | жилдээ | Ч.Улаан<br>О.Чулуунбат |
| | -Банк хоорондын төлбөрийн системийг боловсронгуй болгож, банк хоорондын мэдээлэл дамжуулах нэгдсэн сүлжээ бий болгоно. | жилдээ | Ч.Улаан<br>О.Чулуунбат |
| | -Хөдөө орон нутагт банк, санхүүгийн үйлчилгээг хүргэх, орон нутгийн засаг захиргаа, бизнес эрхлэгчдийн хүч чармайлтад тулгуурлан тухайн бүс нутагт банк, санхүүгийн үйл ажиллагаа явуулах таатай орчныг бүрдүүлэх арга хэмжээ авна. | жилдээ | О.Чулуунбат |
| | -Банкны салбарт гадаад, дотоодын хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, шударга өрсөлдөөнийг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. | жилдээ | О.Чулуунбат |
| | -Зээлийн өрийг багцлан худалдах асуудлыг судлан туршиж хэрэгжүүлнэ. | жилдээ | О.Чулуунбат<br>Ч.Улаан |
| | -Мөнгө угаахын эсрэг үйл ажиллагааны эрх зүйн орчныг бүрдүүлнэ. | жилдээ | О.Чулуунбат |
| | -Иргэний хуулиар зохицуулж байгаа гэрээний харилцаанд нэмэлт болгож санхүү, татвар, бүртгэлийн харилцааг зохицуулах зорилгоор Түрээсийн тухай хууль боловсруулж хэрэгжүүлнэ. | жилдээ | О.Чулуунбат |
| 7. Банкны бус санхүүгийн тогтолцоог төлөвшүүлж, бичил санхүүгийн зуучлалын цар хүрээг өргөжүүлж, тогтвортой орчныг бий болгоно. | -Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг өргөжүүлэх, үр ашигтай ажиллах нөхцөлийг хангах үүднээс эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. | жилдээ | О.Чулуунбат |
| | -Хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, хөдөөгийн санхүүгийн байгууллагы эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. | жилдээ | О.Чулуунбат |
| | -Хадгаламж, зээлийн хоршоонд мөрдөх эдийн засгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтооно. | жилдээ | О.Чулуунбат |

| | | | |
|---|---|---|---|
| 8.Үнэт цаасны зах зээл хөгжих нөхцлийг бүрдүүлж, хэрэгжүүлэх арга хэлбэрийг боловсронгуй болгоно. | -Үнэт цаасны зах зээлийн тухай, Компанийн тухай хуульд хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулна. | жилдээ | С.Гүндэнбал |
| | -Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх хүрээнд үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх стратегийн баримт бичгийг боловсруулж мөрдүүлнэ. | Жилдээ | С.Гүндэнбал |
| | -"Хөрөнгийн бирж" ХК, "Үнэт цаасны төлбөр, тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-ийн үйл ажиллагааг жигдрүүлэн тогтворжуулна. | жилдээ | С.Гүндэнбал<br>Ч.Улаан |
| | -Үнэт цаасаар хөрөнгө оруулах асуудлыг өргөжүүлэх зорилгоор бодлогын хэмжээнд судалж шийдвэрлэнэ. | жилдээ | С.Гүндэнбал<br>Ч.Улаан |
| | -Ипотекээр баталгаажсан үнэт цаасны зах зээлийг үүсгэж хөгжүүлэх асуудлыг судалж шийдвэрлэнэ. | жилдээ | Ч.Улаан |
| | -Үнэт цаасны зах зээлийг либералчилж, сонгодог утгаар нь хөгжүүлэх үндсийг тавина. | жилдээ | С.Гүндэнбал |
| | -Хувьцаат компанийн үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг шинэчлэн тогтоож мөрдүүлнэ. | жилдээ | С.Гүндэнбал |
| | -Үнэт цаасны зах зээлийн талаар олон нийтийг хамарсан мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлыг сайжруулна. | жилдээ | С.Гүндэнбал<br>Ч.Улаан |
| 9. Арилжааны даатгалын эрх зүйн зохицуу-лалтыг боловсронгуй бол-гож, даатгалын хамрах хүрээг өргөжүүлнэ. | -Даатгалын тухай хуультай уялдуулан даатгалын үйл ажиллагааг зохицуулах дүрэм, журам, зааврыг олон улсын жишигт нийцүүлэн шинээр боловсруулж, хэрэгжүүлэх механизмыг боловсронгуй болгоно. | жилдээ | Ч.Улаан |
| | -Даатгалын үйл ажиллагаанд тавих хяналтын системийг үр нөлөөтэй болгох үүднээс даатгалын компаниудын нягтлан бодох бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн аккруэл суурьтай бүртгэлд шилжүүлэх ажлыг зохион байгуулна. | жилдээ | Ч.Улаан |

| | | | |
|---|---|---|---|
| | -Даатгалын зуучлагч, даатгагчийн аудитор, актуарчид тавигдах шалгуурыг тогтоож, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, хяналт тавих ажлыг сайжруулна. | жилдээ | Ч.Улаан |
| | -Даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа компаниудын төлбөрийн чадварыг тогтоож, сайжруулна. | жилдээ | Ч.Улаан |
| | -Дэлхийн банкны техник туслалцааны төслийн хүрээнд Малын даатгалын тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн барина. | жилдээ | Ч.Улаан<br>Д.Насанжаргал |
| | -Бичил санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааны эрсдэлийг бууруулахад даатгалын механизмыг ашиглах боломжийн талаар судалгаа хийж, санал боловсруулна. | жилдээ | Ч.Улаан |
| **ХОЁР. ДЭД БҮТЭЦ,ҮЙЛДВЭРЛЭЛ, ЭКСПОРТЫГ ДЭМЖИХ БОДЛОГЫН ХҮРЭЭНД** | | | |
| *Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, өсөлтийг 5.4 хувьд хүргэнэ.* | | | |
| 1.Түлш, эрчим хүчний салбарын үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээг өргөжүүлж, үр ашгийг дээшлүүлнэ. | - Түлш, эрчим хүчний салбарын бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэн Эрдэнэт-Булган, Баян-Өлгий, Ховд, Увс аймгийн цахилгаан түгээх сүлжээ, Дулааны II цахилгаан станцыг хувьчилж, Багануурын цахилгаан түгээх сүлжээг хувьчлах бэлтгэлийг хангах, Улаанбаатарын цахилгаан түгээх сүлжээг менежментийн гэрээгээр ажиллуулах арга хэмжээ авна. | жилдээ | Б.Жигжид |
| | -Тайшир /Улаанбоом/, Дөргөний УЦС-уудыг барих ажлыг эхлүүлж, Үенчийн УЦС-ыг ашиглалтанд оруулна. | жилдээ | Б.Жигжид |
| | -Улаанбаатар хотын Дулааны үр ашгийн төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, хэрэглэгчдийн 60 хувийг дулаан хангамжийн шинэ системд холбоно. | I-II улирал | Б.Жигжид |
| | -Тайширын УЦС-аас Улиастай болон Арвайхээр-Баянхонгорын хооронд 110 кВ-ын цахилгаан дамжуулах шугам барих ажлыг эхлүүлж, Булган-Мөрөнгийн 110 кВ-ын цахилгаан дамжуулах шугам барьж, Хөвсгөл аймгийн төв болон зарим сумдыг цахилгаан эрчим хүчээр найдвартай хангах нөхцөлийг бүрдүүлнэ. | жилдээ | Б.Жигжид |

| | | | |
|---|---|---|---|
| | -Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан сумын төвийг төвлөрсөн эрчим хүчний системд холбоно. | жилдээ | Б.Жигжид |
| | - Хөдөөгийн малчин айл өрхийг сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээр хангах "Буман нарны гэр" үндэсний хөтөлбөрийн 2 дахь шатны арга хэмжээг нийт аймаг, сумыг хамруулан хэрэгжүүлж, 20000 айл өрхийг нарны цахилгаан үүсгүүрээр хангана. | жилдээ | Б.Жигжид |
| | -Эрчим хүчний нэгдсэн системд 10 кВ, 15 кВ-ын цахилгаан дамжуулах шугамаар холбох боломцоотой сумын төвийн тоог нэмэгдүүлнэ. | жилдээ | Б.Жигжид |
| | -Эрчим хүчний нэгдсэн системд холбоход хүндрэлтэй төв, суурингуудад нар, салхин цахилгаан станц барих талаар нарийвчилсан судалгаа хийнэ. | жилдээ | Б.Жигжид |
| | -Шарын голын орд газрын орчимд нүүрсний нөөц илрүүлэх судалгааны ажлыг үргэлжлүүлж, олборлох нөөц бүхий хэсгийг тогтооно. | жилдээ | Б.Жигжид |
| | - Баруун гурван аймгийн эрчим хүчний газруудын эрчим хүчний өрийг багасгах, барагдуулах арга хэмжээ авна. | эхний хагас жилд | Б.Жигжид |
| | -Байгаль орчныг хамгаалах зорилгоор шахмал түлш, шингэрүүлсэн хийг түлшний шинэ эх үүсвэр болгон ашиглахыг дэмжинэ. | жилдээ | Б.Жигжид |
| 2.Боловсруулах аж үйлдвэрийн салбарын сэргэлтийг баталгаан үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлнэ. | -Эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч, экспортыг 6,0-аас доошгүй хувиар өсгөнө. | жилдээ | Ч.Ганзориг |
| | -Чанарын шаардлага хангасан, дотоодод үйлдвэрлэсэн зарим нэр төрлийн 1,0 хүртэл тэрбум төгрөгийн бүтээгдэхүүнийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр төсвийн байгууллагуудын хэрэгцээнд нийлүүлнэ. | жилдээ | Ч.Ганзориг |

| | | | |
|---|---|---|---|
| | -Импортын зарим бараанд ялгавартай татвар тогтоож, ногдуулах асуудлаар олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | жилдээ | Ч.Ганзориг<br>Ч.Улаан |
| | -Аж үйлдвэрийн парк байгуулах бэлтгэл ажлыг хангаж, арга хэмжээний чиглэл боловсруулж хэрэгжүүлж эхлэнэ. | жилдээ | Ч.Ганзориг |
| | -Эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудад цахим худалдааг нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр боловсруулна. | жилдээ | Ч.Ганзориг<br>Б.Жигжид |
| | -Жижиг, дунд үйлдвэрүүдэд орчин үеийн техник, технологийг нэвтрүүлэх, тэдний эдийн засгийн үр ашгийг сайжруулах зорилгоор лизингийн үйлчилгээний механизм бий болгох арга хэмжээ авна. | жилдээ | Ч.Ганзориг<br>Ч.Улаан |
| 3.Гадаад худалдааны эрх зүйн орчныг боловсронгуй болгож, гадаад худалдааны тэнцлийн алдагдлыг бууруулна. | -Гадаад худалдааны илүү таатай орчин бий болгох чиглэлээр олон улсын байгууллага, гадаад орнуудтай хамтран ажиллана. | жилдээ | Ч.Ганзориг<br>Л.Эрдэнэчулуун |
| | -Гадаад худалдааны статистикийн аргачлалыг боловсронгуй болгох ажлыг үргэлжлүүлнэ. | жилдээ | Ч.Ганзориг<br>Ч.Улаан |
| | -Мэдээлэл, технологийн салбарт хөрөнгө оруулалтыг дэмжих, урамшуулах эрх зүйн механизмыг бий болгох замаар мэдээллийн программ хангамжийг сайжруулж, шинэ нэр төрлийн экспортыг нэмэгдүүлэх орчныг бүрдүүлнэ. | жилдээ | Ч.Ганзориг<br>Б.Жигжид |
| 4.Геологийн судалгаа ашигт малтмалын эрэл хайгуулын ажлын хэмжээг нэмэгдүүлнэ. | -1:50000-ын масштабын геологийн зураглал, ашигт малтмалын ерөнхий эрлийн ажлыг 8.0 мянган ам дөрвөлжин километр талбайд үргэлжлүүлж, 6.0 мянган ам дөрвөлжин километр талбайд шинээр эхлүүлнэ. | II-III улирал | Ч.Ганзориг |
| | -Дундговь, Өмнөговь, Дорноговь аймгийн нутагт 1:200000-ын масштабын геофизикийн хүндийн хүчний судалгааг 25.0 мянган ам.дөрвөлжин километр талбайд үргэлжлүүлнэ. | II-III улирал | Ч.Ганзориг |
| | -Сүхбаатар, Замын-Үүдийн төмөр зам, Мянганы замын дагуух 61,1 мянган ам дөрвөлжин километр талбайд 1:200000-ын улсын геологийн зураг зохиох ажлыг гүйцэтгэнэ. | II-III улирал | Ч.Ганзориг |
| | -Эрдэнэт хот болон Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн төвлөрсөн усан хангамжийн судалгааг дуусгаж, Улаанбаатар хотын хүн амын усны хангамжийн шинэ эх үүсвэр илрүүлэх судалгааг хэрэгжүүлнэ. | II-III улирал | Ч.Ганзориг |

| | | | |
|---|---|---|---|
| | -Улаанбаатар хотын дэвсгэр талбай болон зэргэлдээх бүсэд геоэкологийн региональ судалгааны ажлыг эхлүүлнэ. | жилдээ | Ч.Ганзориг |
| | -Мянганы замын хэвтээ тэнхлэгийн баруун чиглэлийн Архангай аймгийн Ханүйн гүүрээс Завхан аймгийн Яруу сумын төв хүртэлх хэсэгт замын барилгын материалын судалгааг дуусгана. | II-III улирал | Ч.Ганзориг |
| | -Олон улсын техникийн хамтын ажиллагаагаар хэрэгжиж байгаа ашигт малтмалын судалгааг үргэлжлүүлж, Баруун Эрдэнэтийн талбайн геологийн судалгаа, Геологийн төв лабораторийн аккредатчлалыг дэмжих, багажит шинжилгээ, зах зээлийн эдийн засгийн удирдлага, сургалт төслүүдийг хэрэгжүүлж дуусгана. | жилдээ | Ч.Ганзориг |
| 5.Мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, эрсдлийг даван туулах чадавхийг бий болгоно. | -Бүс нутагт зохицсон цөм сүргийг үржүүлж, түүнд түшиглэн мах, сүүний үхэр, мах-ноосны, ноос-махны хонь болон гахай, шувууны аж ахуйг хөгжүүлэх явдлыг дэмжинэ. | жилдээ | Д.Насанжаргал Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | - Шилмэл хээлтүүлэгч хөтөлбөрийг хэрэгжүүлэх, малын чанарыг сайжруулж, ашиг шимийг нь нэмэгдүүлэх чиглэлээр эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүсэд болон төв суурин газарт хийгдэж байгаа үржлийн ажлын менежментийг оновчтой болгоно. | жилдээ | Д.Насанжаргал |
| | -Таримал тэжээл тариалах, тэжээлийн жижиг, дунд үйлдвэрүүдийг хөгжүүлэх үйл ажиллагааг дэмжиж, улс, аймаг, сумын аюулгүйн нөөцөд байх өвс, тэжээлийн нөөцөд овор багатай хүчит тэжээлийн эзлэх хувийн жинг нэмэгдүүлнэ. | жилдээ | Д.Насанжаргал Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | -Мал сүргийг ган зудаас хамгаалахад туслах Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ. | жилдээ | Д.Насанжаргал Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | -Олон улсын санхүүгийн байгууллагаас бэлчээрийн менежментийг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хүрээнд сумын түвшинд бэлчээрийн зураглал, хуваарь гаргаж, хадлан, бэлчээрийн талбайн ашиглалтыг | жилдээ | Д.Насанжаргал Аймгийн Засаг дарга |

| | | | |
|---|---|---|---|
| | сайжруулах замаар өвс бэлтгэл бэлчээрийн даацыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | | |
| | -Ариутгал халдваргүйжүүлэлтийн арга хэмжээний хүрээг өргөтгөж, мал эмнэлгийн ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулна. | жилдээ | Д.Насанжаргал |
| | -Мал эмнэлгийн анхан шатны нэгжүүдэд үйлчилгээний стандартыг нэвтрүүлж, нэгжийн ажил, үйлчилгээний чанарыг сайжруулна. | жилдээ | Д.Насанжаргал |
| | -Махны экспортыг нэмэгдүүлж, 20-иос доошгүй мянган тонн мах экспортолж, хонь, ямааны махны экспортын зах зээлийг өргөжүүлэхэд илүү анхаарна. | жилдээ | Д.Насанжаргал<br>Ч.Ганзориг |
| | -Цагаан хувьсгал үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, хот суурин газрын хүн амын сүү, сүүн бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлнэ. | жилдээ | Д.Насанжаргал |
| 6.Малчид, тариаланчдын зах зээлийн мэдлэгийг дээшлүүлэх, аж ахуйг шинжлэх ухааны үндэстэй эрхлэх арга ажиллагаанд сургах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ. | -ХАА-н шинжлэх ухааны ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлыг өргөжүүлэхийн хамт олон улсын санхүүгийн байгууллагын төсөл, хөтөлбөрийн хүрээнд малчид, тариаланчдад зах зээлийн талаар сургалт явуулж, аж ахуй эрхлэх арга ухаанд сургана. | жилдээ | Д.Насанжаргал |
| | -ХАА-н шинжлэх ухааны ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх төвийн салбарыг 5 аймагт нэмж байгуулна. | жилдээ | Д.Насанжаргал |
| 7.Газар тариалангийн үйлдвэрлэлийн уналтыг зогсоож, тариалангийн талбайг эдийн засгийн эргэлтэд оруулна. | -Хөрс боловсруулах техник, технологийг сайжруулж, уринш боловсруулах цомхотгосон болон тэг элдэншүүлгийн шинэ технологийг нэвтрүүлэх ажлыг өргөжүүлнэ. | жилдээ | Д.Насанжаргал<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | -Үр тарианы үрийн хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангах нөхцөлийг бүрдүүлнэ. | жилдээ | Д.Насанжаргал |
| | -Тариалангийн талбайн хог ургамалтай тэмцэх арга технологийг боловсронгуй болгож нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлнэ. | жилдээ | Д.Насанжаргал<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |

| | | | |
|---|---|---|---|
| | -Хүнс болон хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор тусламжийн хөрөнгөөс бүрдсэн сан, аж ахуйнуудаас эргэн төлөгдсөн хөрөнгө, "Буудайн сан"-гийн хөрөнгийг "тариалан дэмжих сан" болгон өргөтгөн зохион байгуулах удирдлага, зохион байгуулалт, харьяаллын асуудлыг судалж шийдвэрлэнэ | жилдээ | Д.Насанжаргал Ч.Улаан |
| | -Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжсэн мал аж ахуйтай хослуулан эрхлэхийг бүх талаар дэмжинэ. | жилдээ | Д.Насанжаргал Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 8.Усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлэх замаар байгаль, цаг уурын эрсдэлийг багасгаж, тогтвортой ургац авах нөхцөлийг бүрдүүлнэ. | -Сэлэнгэ, Хэрлэн голын ай савд олон жилийн тохируулгатай усан сан байгуулах хайгуул, судалгааны ажлыг хийнэ. | жилдээ | Д.Насанжаргал |
| | -4560 га талбай бүхий 4 услалтын системийг шинээр барих хайгуул, судалгаа, зураг төслийг аж ахуй эрхлэгч, өмчлөгчийн захиалгаар гүйцэтгэнэ. | жилдээ | Д.Насанжаргал |
| | -Үр тариаг усжуулах боломжийн талаар Японы Засгийн газрын тусламжаар судалгааны төсөл хэрэгжүүлнэ. | Жилдээ | Д.Насанжаргал |
| | -Азийн Хөгжлийн Банктай хамтран услалтын системийг засварлах, шинэчлэх чиглэлээр "Газар тариалан" төслийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг эхлүүлнэ. | жилдээ | Д.Насанжаргал |
| | -Хайгуул, судалгаа, зураг төсөл нь хийгдсэн 1629 га талбай бүхий 11 услалтын системийг засварлаж, 440 га талбай бүхий 4 услалтын системийг шинээр барина. | жилдээ | Д.Насанжаргал |
| | -Байгалийн даралтат болон энгийн услалтын системийг сэргээн шинэчилж, тэжээлийн болон үр тарианы ургамал тариалахыг дэмжинэ. | жилдээ | Д.Насанжаргал |
| | -Шинээр томоохон хэмжээний усалгаатай тариалан, хадлан бэлчээр бий болгох боломжтой газар нутгийн хайгуул, судалгаа, зураг төсөл боловсруулах, услалтын систем байгуулах ажлыг иргэн, аж ахуйн нэгжийн захиалга, гадаад орон, олон улсын санхүүгийн байгууллагын туслалцаатайгаар гүйцэтгэхийг дэмжинэ. | жилдээ | Д.Насанжаргал |

| | | | |
|---|---|---|---|
| | -Цас, борооны болон гол мөрөн, булаг шандны усыг тогтоон барих замаар хиймэл нуур, цөөрөм бүхий усалтын систем байгуулан хадлан, тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхийг дэмжинэ. | жилдээ | Д.Насанжаргал Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 9.Бэлчээрт усны найдвартай эх үүсвэрийг бий болгож, бэлчээрийн усан хангамжийг сайжруулна. | -Инженерийн хийцтэй худаг засварлах, шинээр худаг гаргахад дэмжлэг үзүүлнэ. | жилдээ | Д.Насанжаргал Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | -Малчдын өвөлжөө, хаваржаа, шинээр эзэмших бэлчээрт уст цэгийн эрэл хайгуулын ажлыг гадаадын төсөл, хөтөлбөрийн хүрээнд хийнэ. | жилдээ | Д.Насанжаргал Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | -Иргэд, аж ахуйн нэгжүүд өөрийн хөрөнгөөр хадлан, бэлчээрийн талбайд энгийн, болон инженерийн хийцтэй худаг гаргах ажлыг дэмжин урамшуулна. | жилдээ | Д.Насанжаргал Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | -Ус өргөх зориулалттай тоног төхөөрөмж, сэлбэг үйлдвэрлэх бага оврын цех, туршилт судалгааны төв байгуулахад дэмжлэг үзүүлнэ. | жилдээ | Д.Насанжаргал Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 10.Хүн амыг чанарлаг, хүртээмжтэй хүнсээр хангах, хүнсний боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлж, дотоодын хэрэгцээг хангахад чиглэсэн арга хэмжээ авна. | -Гурилыг аминдэм, эрдэс бодисоор баяжуулах технологийг нэвтрүүлж, үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлнэ. | жилдээ | Д.Насанжаргал П.Нямдаваа |
| | -Иоджуулсан давсны хэрэглээг хүн амын 50-60 хувьд хүргэх боломжийг бүрдүүлж, байгалийн давсыг хиймэл бассейнд ургуулах технологийг зарим ордод нэвтрүүлнэ. | жилдээ | Д.Насанжаргал П.Нямдаваа |
| | - Хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, загас боловсруулах жижиг, дунд үйлдвэрийг орон нутагт хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | жилдээ | Д.Насанжаргал П.Нямдаваа |

| | | | |
|---|---|---|---|
| | -Хүнсний хангамжийг сайжруулах үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, гадаадын буцалтгүй тусламжийн хуримтлалын сангаас олгосон зээлийн ашиглалтад тавих хяналтыг сайжруулж, зээлийн эргэн төлөлт, өр авлага барагдуулах ажилд дорвитой ахиц өөрчлөлт гаргана. | жилдээ | Д.Насанжаргал Ч.Улаан |
| | -Импортын хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдийн чанарт тавих хяналтыг сайжруулах зорилгоор хилийн боомтын албадыг хурдавчилсан хяналт, шинжилгээний багаж, төхөөрөмжөөр хангах арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлнэ. | жилдээ | Д.Насанжаргал Ч.Улаан |
| | -Хүнсний аюулгүй байдалтай холбогдсон мэдээллийг хилийн боомтууд, гүний гаалийн байгууллагуудаас шуурхай авах мэдээллийн нэгдсэн сүлжээг бүрдүүлэхэд анхаарна. | жилдээ | Д.Насанжаргал Ч.Улаан |
| | -Загас, загасан бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх талаар гадаад улс оронтой хамтран ажиллана. | жилдээ | У.Барсболд Д.Насанжаргал |
| | - Шатахууны болон мах, гурилын үнийн хөөрөгдлөөс хамгаалах арга хэмжээ авна. | жилдээ | Ч.Ганзориг, нийслэлийн Засаг дарга |
| 11.Ачаа, зорчигч тээврийн үйлчилгээний хүрээг өргөтгөн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангана. | -Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношлогооны станцуудыг бүх аймгийн төвд байгуулна. | жилдээ | Б.Жигжид |
| | -Ази, Европын орнуудтай байгуулсан авто тээврийн харилцааны тухай хэлэлцээрийг хэрэгжүүлж, зарим оронтой байгуулсан тээврийн хэлэлцээрийг шинэчлэх арга хэмжээ авна. Далайн тээврийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааг өргөжүүлэх арга хэмжээ авна. | жилдээ | Б.Жигжид |
| 12.Мэдээлэл холбооны технологийн шинэчлэлийг гүнзгийрүүлэн үйлчилгээний хүрээг тэлж, чанарын түвшинг дээшлүүлнэ. | -Мэдээллийн технологийн шинэ төрлийн хэрэглээ, үйлчилгээг аймгийн төв, томоохон сум, суурин газруудад үе шаттайгаар нэвтрүүлнэ. | жилдээ | Б.Жигжид |
| | -Телефон хэрэглэгчдийн тоог дунджаар 5 хувь нэмэгдүүлнэ. | жилдээ | Б.Жигжид |

| | | | |
|---|---|---|---|
| | -Харилцаа холбооны техник, технологийн шинэчлэлийг гүнзгийрүүлж, сүлжээ, барилга байгууламжийг салбарын хөрөнгө оруулалтаар өргөтгөн шинэчилнэ. | жилдээ | Б.Жигжид |
| | -Шуудангийн үйлчилгээний паркийг шинэчлэх, сумдын салбарыг жингээр хангах арга хэмжээ авна. | жилдээ | Б.Жигжид |
| | -Хот, аймгийн төвийн апслагдсан гэр хороодлыг холбоожуулах шинэ төрлийн технологи нэвтрүүлнэ. | жилдээ | Б.Жигжид |
| | -Орон нутаг болон аймгийн төв, томоохон сум суурин газруудад хөдөлгөөнт холбооны үйлчилгээний хамрах хүрээг нэмэгдүүлнэ. | жилдээ | Б.Жигжид |
| | -Сумдад шуудан хүргэх үйлчилгээ, чанарыг сайжруулна. | жилдээ | Б.Жигжид |
| | -Багийн хэвлэл, шуудан хүргэлтийн давтамжийг нэмэгдүүлнэ. | жилдээ | Б.Жигжид |
| 13."Монголд зочлох жил"-ийг үргэлжлүүлэн зарлаж, гийчин, жуулчдын тоог нэмэгдүүлнэ. | -Монгол орныг дэлхийн аялал жуулчлалын сонирхолтой бүс болгон хөгжүүлэхэд чиглэсэн гадаад сурталчилгааг нэмэгдүүлнэ. | жилдээ | Б.Жигжид |
| | -Жуулчдын үйлчилгээний чанарыг олон улсын жишигт ойртуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ. | жилдээ | Б.Жигжид |
| | -Аялал, жуулчлалын салбарыг бүсчилэн хөгжүүлж, аялалын чиглэл, төрлийг нэмэгдүүлнэ. | жилдээ | Б.Жигжид |
| | -Улаанбаатар хотод жуулчдад зориулсан мэдээллийн төв байгуулна. | жилдээ | Б.Жигжид |
| 14.Нислэгийн аюулгүй байдлыг хангах орчныг сайжруулна. | - Олон улсын иргэний агаарын тээврийн зарим конвенци, хэлэлцээрт нэгдэх, иргэний нисэхийн багц дүрмийг шинэчлэх, иргэний нисэхийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох арга хэмжээ авна. | жилдээ | Б.Жигжид |

| | | | |
|---|---|---|---|
| | -Иргэний нисэхийг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг боловсруулж, баримтлах бодлогын чиглэлийг тодорхойлно. | жилдээ | Б.Жигжид |
| | -Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр өнгөрөх агаарын замын зохион байгуулалтыг боловсронгуй болгох, нислэгийн холбооны нөөц сүлжээг бий болгох үндсэн дээр нислэгийн аюулгүй ажиллагааны хангалтыг дээшлүүлнэ. | жилдээ | Б.Жигжид |
| | -"МИАТ" ХК-ийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авна. | жилдээ | Б.Жигжид |
| | -Орон нутгийн агаарын тээврийн үйлчилгээнд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | жилдээ | Б.Жигжид |
| 15. Бүс нутгийн болон эх газрын тээврийн сүлжээнд Монголын төмөр замын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх арга хэмжээ авна. | -Японы буцалтгүй тусламжаар санхүүжиж байгаа "Төмөр зам, замын байгууламжуудыг сэргээн сайжруулах" төслийн 2 дахь үе шатыг хэрэгжүүлнэ. | жилдээ | Б.Жигжид |
| | -Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн, замын аж ахуйг шинэчлэн сайжруулах, үер уснаас хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ. | жилдээ | Б.Жигжид |
| | -Хилийн өртөөдийг бэхжүүлж, тээврийн мэдээллийн орчин үеийн сүлжээг бий болгоно. | жилдээ | Б.Жигжид |
| | -Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнд засвар шинэчлэлт хийх, Сүхбаатар, Замын-Үүд өртөөдөд ачаа тээврийн терминал барих, өртөөдийн замыг уртасгах, засч сайжруулах ажлыг төмөр замын дотоодын хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж, тээх нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэн Монгол Улсын төмөр замаар дамжин өнгөрөх ачаа тээвэрлэлтийг өмнөх оноос өсгөнө. | жилдээ | Б.Жигжид |
| 16.Авто замын нэгдсэн сүлжээг хөгжүүлнэ. | - Засгийн газраас Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Кувейтын сан болон олон улсын санхүүгийн бусад байгууллагатай байгуулсан гэрээний дагуу авто зам барих ажлыг үргэлжлүүлж, Налайх-Чойрын хатуу хучилттай зам, Арвайхээр-Ховдын чиглэлийн хэсэгчилсэн хайрган хучилттай 93 км замыг тус тус ашиглалтад оруулна. Авто замын зарим чиглэлийг Азийн авто | жилдээ | Б.Жигжид |

| | | | |
|---|---|---|---|
| | Замын сүлжээнд хамруулах арга хэмжээ авна. | | |
| | -Мянганы замын баруун чиглэлд Булган аймгийн Дашинчилэнгээс Архангай аймгийн Гичгэний гүүр хүртэлх 350 км автозамын барилгын ажлыг эхлүүлэхийн зэрэгцээ Гичгэний гүүрээс Завхан аймгийн Яруу сум хүртэлх зам барилгын ажлыг үргэлжлүүлнэ. | жилдээ | Б.Жигжид |
| | -Мянганы замын зүүн чиглэлд Багануур-Өндөрхааны чиглэлийн 200 км хатуу хучилттай зам барих ажлыг эхлүүлнэ. | жилдээ | Б.Жигжид |
| | -Мянганы замын дагуух хөдөлгөөнийг нээх зорилгоор Орхон гол дээр тавих гүүрийн ажлыг санхүүгийн эх үүсвэрийг нь олж эхлүүлнэ. | жилдээ | Б.Жигжид |
| | -Мянганы замын баруун чиглэлийн Завхан голын Сархайрхан, Тэгшийн гол, Шурагийн голын төмөр бетон гүүрүүдийг ашиглалтад оруулна. | жилдээ | Б.Жигжид |
| | -Ховдын Булган-Ярант, Улаангом-Хандгайтын чиглэлийн замыг үргэлжлүүлэн барьж, Эрдэнэт-Булган-Уньт, Өлгий-Цагааннуурын чиглэлийн авто замыг эхлүүлж, Чойр-Замын-Үүдийн авто замын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулна. | жилдээ | Б.Жигжид |
| | - Лүн-Эрдэнэсантын чиглэлийн замыг шинэчлэх ажлыг эхлүүлнэ. | жилдээ | Б.Жигжид |

**ГУРАВ. БҮС НУТАГ, БАЙГАЛЬ ОРЧИН, ХӨДӨӨГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:**

*Бүсчилсэн хөгжлийн зорилтыг хот, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлоготой холбон уялдаатай, үр дүнтэй хэрэгжүүлэх зохион байгуулалтын үндсийг бүрдүүлнэ.*

| | | | |
|---|---|---|---|
| 1.Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль, Бүсүүдийн хөгжлийн дунд хугацаа (2010 он хүртэлх)-ны стратегийг хэрэгжүүлэх | -Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуульд нийцүүлэн Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, тэдгээрийг уялдаатай хэрэгжүүлэх эрх зүйн нэгдмэл орчныг бүрдүүлнэ. | I-II улирал | Ч.Улаан<br>Ц.Нямдорж<br>Ө.Энхтүвшин |

| | | | |
|---|---|---|---|
| төлөвлөлт, зохион байгуулалтын үндсийг бүрдүүлнэ. | -Бүсүүдийн хөгжлийг дэмжих сан, бүсийн хэлэлцээр байгуулах журмыг тогтоож мөрдүүлнэ. | III-IV улирал | Ч.Улаан<br>Ц.Нямдорж |
| | -Бүсүүдийн Зөвлөлийн ажиллах журмыг тогтоож мөрдүүлнэ. | I улирал | Ч.Улаан<br>Ө.Энхтүвшин |
| | -Баруун, Хангайн, Төвийн, Зүүн бүсийн хөгжлийн хөтөлбөр төслийг боловсруулна. | жилдээ | Ч.Улаан<br>А.Цанжид |
| | -Азийн Хөгжлийн Банкны техник туслалцаатай хэрэгжүүлж байгаа "Бүс нутгийн нэгдсэн төлөвлөлтийн чадавхийг бүрдүүлэх" төслийг хэрэгжүүлж дуусган, үр дүнг бүс нутгийн бодлогод тусгана. | жилдээ | Ч.Улаан |
| | -Өвөрхангай аймгийн жишээгээр "Нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын төсөл"-ийг холбогдох аймгууд боловсруулна. | жилдээ | Ч.Улаан<br>Аймгийн Засаг дарга |
| 2.Бүсийн тулгуур төв хотуудын эдийн засгийн чадавхийг үнэлж, цаашид нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлж эхлэнэ. | -Бүсийн тулгуур төв хотуудын Ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж дуусгана. | жилдээ | Ч.Улаан<br>Б.Жигжид |
| | -Бүсийн тулгуур төв хотуудын хөгжлийн нөөц чадавхийг үнэлж, цаашид нэмэгдүүлэх арга замыг судлан тогтоож, Төвийн бүсэд Дархан, Баруун бүсийн тулгуур төв Улиастай түүний орчмын эдийн засгийн чадавхийг дэмжих төслийг хэрэгжүүлж эхлэнэ. | жилдээ | Ч.Улаан<br>Ч.Ганзориг<br>Д.Насанжаргал |
| | -Бүсүүдийн нөөц, чадавхид түшиглэн үйлдвэрлэл, үйлчилгээ, ажил эрхлэлтийг дэмжих зорилгоор дараахь тулгуур төвүүдэд аж үйлдвэрийн парк байгуулах зохистой төрөл, чиглэлийг тогтоож, тэдгээрийг хэрэгжүүлэхэд хувийн хэвшлийн санаачлага, гадаадын зээл, тусламжийг чиглүүлэх санал боловсруулна. Үүнд: | жилдээ | Ч.Ганзориг |
| | • <u>Баруун бүсийн</u> тулгуур төв Ховдод арьс шир, ноос ноолуур боловсруулах, мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортлох чиглэлээр; | жилдээ | Ч.Ганзориг |
| | • <u>Хангайн бүсийн</u> тулгуур төв Эрдэнэтэд экспортод зориулан зэсийн цувимал, арьс ширэн эдлэл, хивс, мах, махан бүтээгдэхүүн боловсруулах чиглэлээр; | жилдээ | Ч.Ганзориг |

| | | | |
|---|---|---|---|
| | ♦ Төвийн бүсийн тулгуур төв Дарханд экспортод зориулан барилгын материал, арьс шир, нэхий эдлэл, мах, махан бүтээгдэхүүн боловсруулах чиглэлээр; | жилдээ | Ч.Ганзориг |
| | ♦ Зүүн бүсийн тулгуур төв Чойбалсанд арьс ширэн эдлэл, хивс, мах, махан бүтээгдэхүүн боловсруулж, экспортлох чиглэлээр; | жилдээ | Ч.Ганзориг |
| | -Бүсийн тулгуур төв хотуудын хүн амын хүнсний хэрэгцээг тогтвортой хангах зорилгоор тэдгээрийн орчим болон таталцлын бүс нутагт эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг хөгжүүлэх төсөл арга хэмжээг дэмжин хэрэгжүүлж эхлэнэ. | жилдээ | Д.Насанжаргал |
| | -Бүсүүд болон бүсийн тулгуур төв хотуудын салбарын төрөлжилт, байршилт, удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох арга хэмжээ авна. | жилдээ | Ч.Улаан |
| 3.Монгол Улсад чөлөөт бүс байгуулах ажлыг эрчимжүүлэх зорилт тавина. | -Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн захиргаа, үйл ажиллагаатай холбогдсон дүрэм, журмыг боловсруулж мөрдүүлэх, Чөлөөт бүсийн Мастер төлөвлөгөө, Ерөнхий төлөвлөгөөг батлан бүсийн Захирагч, Ерөнхий менежерийг томилж, үйл ажиллагааг нь эхлүүлнэ. | I-II улирал | Ч.Улаан<br>Ч.Ганзориг |
| | -Чөлөөт бүсийн дэд бүтцийн сүлжээг сайжруулж, дотоод, гадаадын хөрөнгө оруулалт байрших нөхцөлийг бүрдүүлж эхлэнэ. | жилдээ | Б.Жигжид<br>Ч.Ганзориг |
| | -Замын -Үүд эдийн засгийн чөлөөт бүсийн Мастер төлөвлөгөө, Ерөнхий төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төслүүдийг боловсруулж тус бүсэд шаардлагатай дэд бүтцийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж, дотоод, гадаадын хөрөнгө оруулалт байрших бололцоог бүрдүүлж эхлэнэ. | жилдээ | Б.Жигжид<br>Ч.Ганзориг |
| | -Баян-Өлгий аймгийн Цагааннуурт байгуулах худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын үндсийг тогтоож, хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийг боловсруулна. | жилдээ | Ч.Улаан<br>Ч.Ганзориг<br>Б.Жигжид |

| | | | |
|---|---|---|---|
| | -Чойр хотын дэд бүтцэд түшиглэн, чөлөөт бүсийг зохистой төрөл хэлбэрээр байгуулах боломжийг судлан тогтооно. | I-II улирал | Ч.Улаан Ч.Ганзориг Б.Жигжид |
| 4.Усны нөөцийг зохистой ашиглах бодлого хэрэгжүүлнэ. | -2004 оныг усны жил болгон зарлах асуудал боловсруулж шийдвэрлүүлэн хэрэгжилтийг зохион байгуулна. | I улиралд | Д.Насанжаргал У.Барсболд |
| | -Усыг бохирдуулагчид нь хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар үйлдвэр, ахуйн бохир усыг гол мөрөн, нууранд цэвэрлэгээгүй хаях явдлыг зогсоох арга хэмжээ авна. | II-III улирал | У.Барсболд |
| | -Цэвэр усны нөөцийг хэмнэлттэй ашиглах, үйлдвэрлэлийн хэрэглээний усыг эргүүлэн ашиглах, усыг бохирдохоос сэргийлэх судалгаа, сургалт, сурталчилгааны ажлыг өргөн зохион байгуулж, Усны судалгааны үндэсний төв байгуулах асуудлыг шийдвэрлүүлнэ. | III-IV улирал | У.Барсболд |
| | -Томоохон гол мөрний сав газрын усны менежментийг сайжруулж, түүнд олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ. | жилдээ | У.Барсболд |
| | -Уул уурхайн салбарт усыг хэрхэн ашиглаж байгаад хяналт шалгалт хийж, үйлдвэрлэлийн явцад тухайн газар нутгийн усны байгалийн горимыг нөхөн сэргээх ажиллагааг зохион байгуулна. | жилдээ | У.Барсболд Ч.Ганзориг |
| | -Усны хэрэглээний норм, норматив болон нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээг шинэчлэн боловсруулна. | I-II улирал | У.Барсболд |
| 5. Ойг нөхөн сэргээх ажлыг нэмэгдүүлэхийн хамт биологийн төрөл, зүйлийн хамгаалалтыг сайжруулна. | -Тарьц суулгацны нөөцийг нэмэгдүүлэн иргэд, байгууллагын ойг нөхөн сэргээх үйл ажиллагааг дэмжиж, зарим бүс нутагт тодорхой төсөл хэрэгжүүлэх замаар нийт 16280 га талбайг ойжуулна. | I-III улирал | У.Барсболд |
| | -Ойн хортон шавьжны судалгааг 400.0 мянган га талбайд хийж, ойн хортон шавьжтай тэмцэх ажлын цар хүрээг нэмэгдүүлж, 24.0 мянган га талбайд устгалтын ажил хийнэ. | жилдээ | У.Барсболд |
| | -500,0 мянган га-гаас доошгүй талбайд үлийн цагаан оготно, 40,0 мянган га-гаас доошгүй талбайд царцааг хими, биологийн болон механик аргаар устгах ажлыг орон нутгийн оролцоотойгоор хийнэ. | жилдээ | Д.Насанжаргал Ч.Улаан Аймгийн Засаг дарга |

| | | |
|---|---|---|
| -Туул голын сав газрын зарим хэсэг, Сэлэнгэ аймгийн нутгийн заагт орших Хонин нуга, Булган аймгийн Булган уул, Ховд, Баян-Өлгий аймгийн Мөнххайрхан уул, Хөвсгөл аймгийн Дэархийн голын эх, Сүхбаатар аймгийн Шилийн Богд, Алтан-Овоо, Дорнодын Тамсаг зэрэг газар нутгийг орон нутгийн саналд үндэслэн улсын тусгай хамгаалалтад авах асуудлыг судалж шийдвэрлэнэ. | жилдээ | У.Барсболд |
| -Газрын хэвлийн баялгийн ашигт элементийн хаягдлыг багасгах, түүнээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авч, ашиглалтын явцад үүссэн байгаль орчны доройтлыг нөхөн сэргээх арга ажиллагааг сайжруулна. | жилдээ | У.Барсболд<br>Ч.Ганзориг |
| -Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, түүнд нийт ард иргэдийн оролцоо, идэвхи санаачлагыг дэмжиж, гамшигтай тэмцэх тогтолцоог бэхжүүлнэ. | жилдээ | У.Барсболд<br>Ө.Энхтүвшин |
| -Ховор, нэн ховордсон зарим амьтдын байршил, тархац, тоо толгойн судалгааг явуулж, зориудаар үржүүлэх, сэргээн нутагшуулах арга хэмжээ авна. | жилдээ | У.Барсболд |
| -Эмийн болон хүнсний, түүнчлэн техникийн үнэт ургамлыг нутагшуулах, тарималжуулах замаар үйлдвэрлэлийн хэмжээнд ашиглах, унаган болон ховордсон, аж ахуйн чухал ач холбогдол бүхий амьтан, ургамлын гаралтай олзворын зүйлсийг эдийн засгийн ашиг сонирхлын үүднээс гадаадад гаргахыг хязгаарлах механизм бий болгоно. | жилдээ | У.Барсболд |
| -Байгаль орчныг хамгаалах уламжлалт ёс заншил, хууль тогтоомжийг сурталчлах ажлыг эрчимжүүлж, байгаль орчны мэдээлэл, сурталчилгааны студи байгуулах арга хэмжээ авна. | жилдээ | У.Барсболд |
| -Орчны цацрагийн хяналтын сүлжээг автомат болон нарийвчлал сайтай техник, тоног төхөөрөмжөөр хангаж, цацрагийн хэмжлийн чанарыг сайжруулна. | жилдээ | У.Барсболд |
| -Улаанбаатар хотод агаар, орчны бохирдлын хяналтыг сайжруулах зорилгоор орчны хяналтын багаж төхөөрөмж бүхий 2 харуулыг нэмж байгуулан ажиллуулна. | жилдээ | У.Барсболд |

| | | | |
|---|---|---|---|
| | -Хог хаягдлыг бууруулах эрх зүйн үндсийг бүрдүүлэн Дархан, Эрдэнэт, Чойбалсан хотуудад хог хаягдлыг ангилан ялгах анхан шатны арга хэмжээг хэрэгжүүлж, Улаанбаатар хотод хог боловсруулах үйлдвэр байгуулах асуудлыг шийдвэрлэнэ. | жилдээ | У.Барсболд |
| | -Ахуйн болон үйлдвэрлэлийн хаягдлыг зайлуулах, тээвэрлэх, байршуулах эрх зүйн орчныг бүрдүүлэн, хүн ам, байгаль орчныг хаягдлын сөрөг нөлөөнөөс хамгаалах менежментийг хэвшүүлнэ. | Жилдээ | У.Барсболд |
| | -Гадаадын аж ахуйн нэгжид ашиглуулах газрын судалгааг гаргаж, урт хугацаагаар түрээслэх хөшүүргийн журам тогтоож мөрдүүлнэ. | I-II улирал | У.Барсболд |
| | -Хог хаягдлыг зайлуулах үйл ажиллагааг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдээр гүйцэтгүүлэх эдийн засгийн урамшууллын хөшүүргийг бүрдүүлнэ. | II-III улирал | У.Барсболд |

**ДӨРӨВ. ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:**

*Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн хүрээнд хүний хөгжлийг хангах орчныг бүрдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, нийгмийн суурь үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг сайжруулна.*

| | | | |
|---|---|---|---|
| 1.Боловсролын салбарын шинэчлэлийг гүнзгийрүүлж, бүх шатны сургуулийн сургалтын чанарт ахиц гаргана. | -Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын шинэ стандартын туршилтыг эхлэхийн зэрэгцээ ерөнхий боловсролын сургуулийг 11 жилийн тогтолцоонд шилжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | жилдээ | А.Цанжид |
| | -Малчдын бага насны хүүхэд болон төв, суурин газрын цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын сургалтад хамруулах ажлыг өргөжүүлж, сургуулийн өмнөх боловсролын хамралтыг 48.5 хувьд хүргэнэ. | жилдээ | А.Цанжид Аймгийн Засаг дарга |
| | -Дотуур байрны ахуй нөхцөлийг сайжруулж, суурь боловсролын хамран сургалтыг 90.0 хувьд хүргэнэ. | IV улирал | А.Цанжид Аймаг, нийслэлийн Засаг дарга |

| | | |
|---|---|---|
| -Бичигтэн болох НҮБ-ын 10 жилийн үндсэн зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 6.5 мянган иргэнд бичиг үсгийн боловсрол олгоно. | жилдээ | А.Цанжид<br>Аймгийн Засаг дарга |
| -Хөдөөгийн сургуулийг багшаар хангах ажлыг зохион байгуулж ахиц гаргана. | жилдээ | А.Цанжид<br>Аймгийн Засаг дарга |
| -Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох замаар суралцагчдын тоог нэмэгдүүлж, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэн бэлтгэх ажлын чанарыг сайжруулна. | жилдээ | А.Цанжид |
| -Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг магадлан итгэмжлэх ажлыг эхлүүлнэ. | I-II улирал | А.Цанжид |
| -Эмзэг бүлгийн болон 4 ба түүнээс дээш хүүхэд нь ерөнхий боловсролын сургуульд зэрэг суралцдаг өрхийн нэг хүүхдийн хичээлийн хэрэглэлийг төр хариуцаж, сурах бичгийг шинэ стандартад нийцүүлэн шинэчлэх ажлыг үргэлжлүүлнэ. | III улирал | А.Цанжид |
| -Бүрэн дунд сургуулиудыг компьютержүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж дуусгана. | жилдээ | А.Цанжид |
| - Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад технологийн мэдлэг эзэмшүүлэх нөхцөл бүрдүүлнэ. | жилдээ | А.Цанжид |
| -Дээд боловсролын сургалтын цөм агуулга болон орчны стандартыг боловсруулан туршина. | III-IV улиралд | А.Цанжид |
| -Дээд боловсролын байгууллагын магадлан итгэмжлэлийг үргэлжлүүлж, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг эхлүүлнэ. | жилдээ | А.Цанжид |
| -Дээд боловсролын байгууллагуудын аттестатчлалын ажлыг зохион байгуулж эхлэнэ. | жилдээ | А.Цанжид |
| -Их, дээд сургууль, коллежид шинээр элсэн сурах оюутнуудаас сургалтын төлбөрийн зээл, хөнгөлөлт, буцалтгүй тусламжид хамрагдах тоог нэмэгдүүлнэ. | II улирал | А.Цанжид<br>Ч.Улаан |
| -Сумдын соёлын төв, номын санг хөгжим, техник хэрэгсэл, шинэ номоор хангах арга хэмжээг үргэлжлүүлэн авна. | жилдээ | А.Цанжид |

| | | | |
|---|---|---|---|
| | -"Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг сэргээн засварлах, хадгалж хамгаалах үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ. | жилдээ | А.Цанжид |
| | -Шинжлэх ухаан, технологийн салбарыг хөгжүүлэх "Мастер төлөвлөгөө" боловсруулна. | жилдээ | А.Цанжид |
| 2.Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгоно. | -Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор Азийн Хөгжлийн Банктай хамтран хэрэгжүүлэх "Эрүүл мэндийн салбарын хөгжил II" хөтөлбөрийн хүрээнд эрүүл мэндийн салбарын төсвийн төлөвлөлт, боловсон хүчний чадавхийг сайжруулах арга хэмжээ авна. | жилдээ | П.Нямдаваа аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | -Эрүүл мэндийн үндэсний тооцоог нэвтрүүлэх ажлыг бүрэн хэрэгжүүлж, салбарын цаашдын бодлого төлөвлөлттэй уялдуулах чиглэлээр ажиллана. | жилдээ | П.Нямдаваа |
| | -Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг гүнзгийрүүлж даатгалын хамралтыг сайжруулах, эрүүл мэндийн даатгалаас эмнэлгүүдийг санхүүжүүлэх арга механизмийг боловсронгуй болгох болон даатгалын байгууллагын чадавхийг сайжруулна. | жилдээ | П.Нямдаваа |
| | -Эрүүл мэндийн суурь тусламжид зарцуулах санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэн стандартын дагуу санхүүжүүлнэ. | жилдээ | П.Нямдаваа |
| 3.Хөдөөгийн хүн амын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор материаллаг баазыг нь бэхжүүлнэ. | -Нэг иргэнээр тооцох санхүүжилтийн механизмыг сумын эмнэлэгт туршина. | жилдээ | П.Нямдаваа |
| | -Азийн Хөгжлийн Банктай хамтран хэрэгжүүлэх "Эрүүл мэндийн салбарын хөгжил II" хөтөлбөрийн хүрээнд 10 сумын эмнэлгийн барилгыг шинээр барих, 20 сумын эмнэлэг, сум дундын 3 эмнэлгийн барилгад их засвар хийх, зайлшгүй шаардлагатай багажаар хангах ажлыг хэрэгжүүлнэ. | жилдээ | П.Нямдаваа |
| | -Дорнод, Өвөрхангай аймгийн бүсийн оношилгоо эмчилгээний төвийн барилга болон 5 аймгийн нэгдсэн эмнэлгийн барилгад их засвар хийнэ. | II-III улирал | П.Нямдаваа |

| | | | |
|---|---|---|---|
| | -Аймгийн төвөөс алслагдсан сумын эмнэлгүүд, сум дундын эмнэлгүүд, Сэлэнгийн Зүүнхараа, Өвөрхангайн Хархорин, Завханы Тосонцэнгэл, Хэнтийн Бор-Өндөр сумын нэгдсэн эмнэлгүүдийг тоног төхөөрөмжөөр хангаж, засварлах ажлыг зохион байгуулна. | жилдээ | П.Нямдаваа |
| | -Нийслэлийн болон аймгуудын төв, сумдын эмнэлгийн түргэн тусламжийн авто машины парк шинэчлэлтийг үргэлжлүүлэн хийнэ. | жилдээ | П.Нямдаваа |
| 4.Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлнэ. | -Нийгмийн эрүүл мэндийн бодлого, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн зохион байгуулалтыг шинэ шатанд гаргаж, ахмад настны эрүүл мэнд, Нөхөн үржихүйн эрүүл мэнд, Тахир дутуу иргэдийг дэмжих хөтөлбөрийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ. | жилдээ | П.Нямдаваа |
| | -Бүсийн оношилгоо, эмчилгээний төвүүдэд байгалийн гаралтай халдварт өвчний лабораторийн оношилгооны арга нэвтрүүлнэ. | жилдээ | П.Нямдаваа |
| | -Дархлаажуулалтын талаар ерөнхий боловсролын сургуулийн эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрт тусгаж, багш нарт бүсчилсэн сургалт зохион байгуулна. | II-IV улирал | П.Нямдаваа А.Цанжид |
| | -Дэлхийн вакцины сантай хамтран заавал хийх дархлаажуулалтад сахуу-татран-хөхүүл ханиад–В гепатитийн хавсарсан дөрөвт вакциныг шинээр, үе шаттайгаар нэвтрүүлнэ. | жилдээ | П.Нямдаваа |
| 5.Эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, эндэгдлийг бууруулах ажлын далайцыг өргөжүүлнэ. | -Аймгийн төв, сумын эхчүүдийн амрах байрын нөхцөлийг сайжруулна. | жилдээ | П.Нямдаваа |
| | -Амаржих газрууд, аймгийн нэгдсэн эмнэлгийн төрөх тасгийн оношлогоо, эмчилгээний багаж, тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах ажлыг үргэлжлүүлнэ. | жилдээ | П.Нямдаваа |
| | -Аймгийн нэгдсэн эмнэлгүүдэд хүүхдийн эрчимт эмчилгээ, яаралтай тусламжийн нэгжийг зохион байгуулж, хүүхдийн өвчний цогц менежментийн стандарт, шаардагдах тоног төхөөрөмжийн жагсаалтыг боловсруулна. | II-III улирал | П.Нямдаваа |
| | -Ураг, нярайн тусламж үйлчилгээний стратеги боловсруулж хэрэгжүүлнэ. | II-IV улирал | П.Нямдаваа |

| | | | |
|---|---|---|---|
| | -Хүүхэд, хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд салбар дундын оролцоог сайжруулна. | жилдээ | П.Нямдаваа |
| | -Хүүхдийн эрүүл өсч бойжих ээлтэй орчныг бүрдүүлэх, дэмжих талаар орон нутагт сурталчилгаа зохион байгуулна. | жилдээ | П.Нямдаваа |
| 6.Эмийн үндэсний бодлогын хэрэгжилтийн хяналтыг сайжруулна. | -Эмийн бүртгэл, хяналтыг сайжруулах зорилгоор эмийн хяналтын лабораторийг зохион байгуулна. | жилдээ | П.Нямдаваа |
| | -Эмийн гаж нөлөөг бүртгэх тогтолцоог бий болгоно. | I-II улирал | П.Нямдаваа |
| | -Эм, эмнэлгийн багаж хэрэгслийг сонгон шалгаруулалтаар нийлүүлэх ажлыг боловсронгуй болгож хэрэгжүүлнэ. | жилдээ | П.Нямдаваа |
| | -Эмийн үндэсний бодлогын хэрэгжилтэд үнэлгээ өгнө. | II-III улирал | П.Нямдаваа |
| 7.Эрүүл мэндийн технологи үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах, эрүүл мэндийн салбарт өөрчлөлт шинэчлэл, хувьчлалыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | -Эмнэлгийн дотоод сүлжээтэй эмнэлгийн тоог нэмэгдүүлнэ. | жилдээ | П.Нямдаваа |
| | -Эрүүл мэндийн салбарын хувьчлал, өөрчлөн байгуулалтын үзэл баримтлалыг боловсронгуй болгож, тус салбарт өөрчлөлт шинэчлэлт хийх, хувьчлах байгууллагуудын жагсаалтыг батлуулж мөрдүүлнэ. | жилдээ | П.Нямдаваа |
| | -Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах тогтолцоог бүрдүүлнэ. | жилдээ | П.Нямдаваа |
| | -Бүх ард түмний спартакиадыг улс орон даяар зохион байгуулна. | I-II улирал | П.Нямдаваа |
| | -Өрхийн болон сумын эмнэлгийн түвшинд үзүүлэх эрүүл мэндийн суурь тусламжийн багцыг тодорхойлсны үндсэн дээр суурь тусламж үзүүлэх тогтолцооны эрх зүйн орчныг бүрдүүлнэ. | II-III улирал | П.Нямдаваа |
| | - Хүн амын эрүүл мэндийг хамгаалах зорилтын хүрээнд нийтийн биеийн тамир, спортыг дэмжинэ. | жилдээ | П.Нямдаваа |
| 8.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг идэвхижүүлэх замаар ажилгүйдлийн түвшинг | -Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлттэй уялдуулан ажил хайгч 30000-аас доошгүй хүнийг сул, чөлөөтэй ажлын байранд хөдөлмөр эрхлэлтийн албадаар дамжуулан ажилд зуучилж оруулна. | жилдээ | Ш.Батбаяр Аймаг, нийслэлийн Засаг дарга |

| | | | |
|---|---|---|---|
| эдийн засгийн идэвхитэй хүн амын 4,5 хувиас илүүгүй байлгана. | -Ажлын байр шинээр бий болгосон буюу ажилгүй иргэдэд шинэ мэргэжил олгох, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр үйлдвэрлэл дээрх сургалтыг зохион байгуулж, ажлын байраар хангасан ажил олгогчдод дэмжлэг туслалцаа үзүүлнэ. | жилдээ | Ш.Батбаяр Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | -Хөдөлмөр зарцуулалт ихтэй, мэргэжил шаардахгүй нийтийг хамарсан ажил зохион байгуулж, нийгмийн эмзэг бүлгийн 10500 хүртэл иргэнийг хамруулна. | жилдээ | Ш.Батбаяр |
| | -Хувиараа болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр аж ахуй эрхлэх иргэд, аж ахуй нэгжид хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас банк болон банк бус санхүүгийн байгууллагаар дамжуулан жижиг зээл олгох журмыг боловсронгуй болгох замаар 4500-гаас доошгүй ажлын байр бий болгоно. | жилдээ | Ш.Батбаяр У.Барсболд Д.Насанжаргал Ч.Ганзориг |
| | -Ажилгүй иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах үйлчилгээг өргөжүүлнэ. | жилдээ | Ш.Батбаяр Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | -Мэргэжлийн болон давтан сургалтад 12000-аас доошгүй хүнийг хамруулна. | жилдээ | Ш.Батбаяр |
| | -Мэргэжлийн сургалтын байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах, сургалтад хамрагдсан иргэдийг ажил эрхлэн орлогын эх үүсвэртэй болоход нь бүх талын дэмжлэг үзүүлнэ. | жилдээ | Ш.Батбаяр Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | -Бичил аж ахуйн нэгжийг албан ёсоор бүртгүүлж, үйл ажиллагаа явуулахад нь туслалцаа үзүүлэх инкубаторын төвийг зарим аймаг, дүүрэгт байгуулж, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдэд мэргэжлийн зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг туршина. | жилдээ | Ш.Батбаяр А.Цанжид |
| | -Нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд хөдөлмөр эрхлэх чадвар олгох, мэргэжлийн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг өргөжүүлнэ. | жилдээ | Ш.Батбаяр Аймаг, нийслэлийн Засаг дарга |

| | | |
|---|---|---|
| -Гадаадад хөдөлмөрийн гэрээгээр болон дадлагажигчаар ажиллах иргэдийн тоог нэмэгдүүлж, гадаадад ажиллах хүч, дадлагажигч илгээж байгаа зуучлагч аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг зохицуулах арга хэрэгслийг боловсронгуй болгож, хяналтыг сайжруулна. | жилдээ | Ш.Батбаяр |
| -Малчдын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн байдлыг сайжруулах зорилгоор газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй, гахай, шувуу, жимс зэрэг аж ахуй эрхлэх ур чадвар эзэмшүүлэх, суурин амьдралд шилжихэд нь дэмжлэг үзүүлнэ. | жилдээ | Ш.Батбаяр |
| -Хөдөөгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, мал аж ахуй, газар тариалангийн чиглэлээр ажиллах иргэдэд зориулсан жижиг зээлийн үйлчилгээг өргөжүүлнэ. | жилдээ | Ш.Батбаяр |
| -Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд хөтөлбөрийг батлуулж хэрэгжүүлнэ. | жилдээ | Ш.Батбаяр |
| -Албан бус хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн үйл ажиллагааг судлах талаар Олон улсын банк, санхүү, эдийн засгийн байгууллагуудтай хамтран ажиллана. | жилдээ | Ш.Батбаяр |
| -Төрийн албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэх асуудлыг судлан боловсруулж шийдвэрлүүлнэ. | жилдээ | Ш.Батбаяр |
| -Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын улмаас тахир дутуу болсон иргэнд нөхөн төлбөр олгох тухай хуулийн төсөл боловсруулна. | жилдээ | Ш.Батбаяр |
| -Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэдээллийн төв байгуулах асуудлыг боловсруулж шийдвэрлүүлнэ. | жилдээ | Ш.Батбаяр |
| -Ажилгүйдлын даатгалын санг хөдөлмөр эрхлэлтийн бодлоготой уялдуулан зарцуулах эрх зүйн орчныг бий болгоно. | жилдээ | Ш.Батбаяр |
| -Нийгмийн түншлэлийн механизмыг хэрэгжүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. | жилдээ | Ш.Батбаяр |
| -Хүн амын зохистой өсөлтийн талаар олон нийтийн санал бодлыг судлан, хүн амын талаар төрөөс баримтлах бодлогод тусган хэрэгжүүлнэ. | жилдээ | Ш.Батбаяр |
| -Аймаг, сум бүр ажилгүйдэл, ядуурлыг бууруулах хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ. | жилдээ | Ш.Батбаяр, Аймаг, нийслэлийн Засаг дарга |

| | | | |
|---|---|---|---|
| | -Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн удирдах ажилтны цалин хөлсийг байгууллагын нь ажлын үр дүнтэй холбон олгох, урамшуулах журам боловсруулж мөрдүүлнэ. | жилдээ | Ө.Энхтүвшин<br>Ш.Батбаяр<br>Ч.Улаан |
| | -2004 оныг Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил болгон тэмдэглэх ажлыг зохион байгуулна. | жилдээ | Ш.Батбаяр |
| 9.Өрхийн тогтвортой амьжиргааг дэмжих замаар хүн амын орлогыг нэмэгдүүлнэ. | -Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр "Тогтвортой амьжиргаа" төслийг сонгосон аймгуудад үргэлжлүүлэн хэрэгжүүлж, ядуучуудад үзүүлэх үйлчилгээний хүртээмж, үр дүнг сайжруулна. | жилдээ | Ш.Батбаяр |
| | -Хөдөө аж ахуйн хөгжлийн олон улсын сангийн тусламжтайгаар Хөдөөгийн ядуурлыг тогтвортой бууруулах хөтөлбөрийг холбогдох аймгуудад хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | жилдээ | Д.Насанжаргал<br>Ш.Батбаяр |
| | -Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 36000 төгрөгт хүргэж нэмэгдүүлэх асуудлыг судлаж шийдвэрлэнэ. | II улирал | Ш.Батбаяр |
| | -Төсвийн байгууллагын ажилтны цалин хөлсийг нэмэгдүүлэх асуудлыг судлаж хэрэгжүүлэх арга замыг тодорхойлно. | I улирал | Ш.Батбаяр |
| | -Бүрэн болон хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ, дундаж тэтгэврийг нэмэгдүүлнэ. | I улирал | Ш.Батбаяр |
| | -Нийгмийн халамжийн сангаас олгох хүүхэд асарсны тэтгэмжийн хэмжээг 20 хувиар нэмэгдүүлнэ. | жилдээ | Ш.Батбаяр |
| | -Тэтгэврийн насанд хүрээгүй нөхөн олговор авагчдын нөхөн олговрын доод хэмжээг бүрэн тэтгэврийн доод хэмжээтэй уялдуулна. | жилдээ | Ш.Батбаяр |
| 10.Нийгмийн хамгааллын тогтолцоог боловсронгуй болгох, чадавхийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг дэс дараатай | -Тэтгэврийн даатгалын нэрийн данс нээлгэх заавал даатгуулагчдын хамрагдалтыг 100 хувьд хүргэж, нэрийн дансанд хуримтлагдсан хөрөнгийн хэмжээ, хүүг даатгуулагчдад мэдээлэх тогтолцоог бүрдүүлж, хагас хуримтлал бий болгох урьдчилсан нөхцөлийг хангах арга хэмжээ авна. | жилдээ | Ш.Батбаяр |

| | | | |
|---|---|---|---|
| хэрэгжүүлнэ. | -Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон нийгмийн даатгалд хамрагдаагүй байгаа иргэдийг нийгмийн даатгалд хамруулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ. | жилдээ | Ш.Батбаяр<br>Ц.Нямдорж |
| | -Хараа хяналтгүй хүүхдүүдийн асуудлыг бүрэн шийдвэрлэх, цаашид таслан зогсоох талаар цогцолбор арга хэмжээг хэрэгжүүлнэ. | жилдээ | Ш.Батбаяр<br>Ц.Нямдорж |
| | -Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын улмаас тахир дутуу болсон иргэдийн тахир дутуугийн тэтгэвэр авч байх хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэл болон тэднийг асрах, сувилах, эмчлэх зардлыг ҮОМШӨ-ний даатгалын сангаас нөхөн төлөх асуудлыг боловсруулж шийдвэрлүүлнэ. | жилдээ | Ш.Батбаяр<br>Ц.Нямдорж |
| | -Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг сайжруулах, ялангуяа малчид, иргэдийн нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрийг барагдуулах орлогын төлөвлөгөө биелүүлэх, шимтгэлийн өр авлагыг бууруулах, хариуцлагыг чангатгах арга хэмжээ авч, нийгмийн даатгалын сангуудын хөрөнгийн эргэлт, чадавхийг сайжруулна. | жилдээ | Ш.Батбаяр |
| | -Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэн шинэчилнэ. | жилдээ | Ш.Батбаяр |
| | -Нийгмийн хамгааллын салбарын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр Мастер төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ. | II улирал | Ш.Батбаяр |
| | -Нийгэм, хамт олонд түшиглэсэн халамж, үйлчилгээний шинэ хэлбэрийг турших арга хэмжээг хэрэгжүүлнэ. | жилдээ | Ш.Батбаяр |
| 11.Хүн амд хүргэх нийтийн аж ахуйн үйлчилгээний хүрээг өргөтгөн хүртээмжийг нэмэгдүүлнэ. | -Архангай, Булган, Дундговь, Өмнөговь, Дорноговь, Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгийн нийтийн аж ахуйг хөгжүүлэх 2 дахь шатны төслийн барилгын ажлыг эхэлнэ. | II улиралд | Б.Жигжид<br>Аймгийн Засаг дарга |
| | -Улаанбаатар хотын гэр хорооллын усан хангамжийг сайжруулах арга хэмжээг эрчимжүүлнэ. | Жилдээ | Б.Жигжид<br>Нийслэлийн Засаг дарга |

| | | | |
|---|---|---|---|
| | -Нийт 19 аймгийн 52 суманд нийтийн халуун усыг шинээр барих болон шинэчлэх ажлыг хийж, халуун усны үйлчилгээг сэргээнэ. | Жилдээ | Б.Жигжид Аймгийн Засаг дарга |
| | -Усны үндэсний хөтөлбөрийн 2 дахь шатны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, цэвэрлэх байгууламжийн дэд хөтөлбөрийг боловсруулж батлуулахын зэрэгцээ орон нутгийн цэвэрлэх байгууламжуудын техникийн шийдлийн асуудлыг судалж шийдвэрлэнэ. | Жилдээ | Б.Жигжид У.Барсболд |
| | -Хүн амын хэрэглээний эрдэсжилт, хатуулаг ихтэй усыг зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна. | Жилдээ | Б.Жигжид Аймгийн Засаг дарга |
| 12."Орон сууц" үндэсний хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг сайжруулна. | - Гадаадын зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгө, төсвийн болон бизнесийн байгууллагуудын хөрөнгө оруулалтын төслүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, 2004 онд 2000-аас доошгүй айлын орон сууцыг ашиглалтад оруулж, орон сууцны фондыг нэмэгдүүлнэ. | Жилдээ | Б.Жигжид |
| | -Орон сууцны зээлийн сангаас зээл олгох журам боловсруулж, эхний ээлжинд залуу гэр бүл, төрийн албан хаагчдад урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгоно. | Жилдээ | Б.Жигжид Ш.Батбаяр |
| | -Орон гэргүй, тэнэмэл амьдралтай иргэдийг гэр, орон сууцаар хангах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | Жилдээ | Б.Жигжид Ш.Батбаяр |
| | -Орон сууцны хангамжийг сайжруулах, нэмэгдүүлэх зорилгоор үл хөдлөх хөрөнгөөр барьцаалсан орон сууцны зээлийн бүтэц, тогтолцоог зах зээлийн харилцааны зарчимд нийцүүлэн бий болгож, холбогдох эрх зүйн орчныг бүрдүүлнэ. | Жилдээ | Ч.Улаан Ц.Нямдорж |
| | -Байгууллагын мэдлийн орон сууцыг хувьчлах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулна. | Жилдээ | Ө.Энхтүвшин Б.Жигжид |
| | -Орон сууц барихад зориулсан ипотекээр баталгаажсан үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэхэд шаардагдах эрх зүйн орчныг бүрдүүлж, түүнийг дагнан хариуцсан нэгжийг бий болгоно. | Эхний хагас жилд | Б.Жигжид О.Чулуунбат Ч.Улаан |

**ТАВ. ГАДААД БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ ХҮРЭЭНД:**

*Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалд тодорхойлсон зарчим, чиглэлийг улс орны болон дэлхий дахины нөхцөл байдалтай уялдуулан тууштай хэрэгжүүлж, үндэсний язгуур эрх ашиг, тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн бие даасан, нээлттэй, олон тулгуурт гадаад бодлогыг идэвхтэй явуулна.*

| | | | |
|---|---|---|---|
| 1.Хөрш орнуудтай харилцах уламжлалт харилцааг улам өргөжүүлнэ. | -ОХУ, БНХАУ-тай харилцаа, хамтын ажиллагааны давтамжийг хадгалах, харилцан тохирсон асуудлуудыг хэрэгжүүлэх, хил орчмын бүс нутгийн болон хоёр талын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд урьдын адил анхаарч, хоёр хөрштэй дээд түвшний айлчлал, улс төрийн яриа хэлэлцээг үргэлжлүүлнэ. | жилдээ | Л.Эрдэнэчулуун |
| | -Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх үүднээс Засгийн газар хоорондын комиссын үйл ажиллагааг идэвхжүүлнэ. | жилдээ | Л.Эрдэнэчулуун |
| | -Дамжин өнгөрөх тээврийн асуудлаар ОХУ, БНХАУ-тай өмнө эхэлсэн яриа хэлэлцээг НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурлын дэмжлэгтэйгээр үргэлжлүүлж, Ерөнхий хэлэлцээр байгуулах чиглэлээр ажиллана. | жилдээ | Л.Эрдэнэчулуун |
| 2. Найрсаг харилцаат орнууд болон олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаа өргөжүүлнэ. | -АНУ, Япон, ХБНГУ, Их Британи, Канад, Финлянд, Нидерланд зэрэг өрнө, дорнын өндөр хөгжилтэй орнуудтай тогтоосон харилцааг урагшлуулан хөгжүүлэх, эдийн засгийн хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, өндөр дээд хэмжээний айлчлалыг хэрэгжүүлэх чиглэлээр ажиллана. | жилдээ | Л.Эрдэнэчулуун |
| | -АСЕАН-ы гишүүн улс орнууд болон Турк, Польш, Украйнтай хоёр талын харилцааг хөгжүүлэх, хамтын ажиллагааны хүрээг өргөжүүлэхийг зорино. | жилдээ | Л.Эрдэнэчулуун |
| | -Ойрхи Дорнодын, тухайлбал Египет, Катар, Оман зэрэг оронтой хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг бэхжүүлэх, зээл, тусламжийг нэмэгдүүлэх боломжийг эрэлхийлнэ. | жилдээ | Л.Эрдэнэчулуун |

| | | | |
|---|---|---|---|
| | -НҮБ, түүний системийн болон олон улсын бусад байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, тэдгээрийн хүч, боломжийг улс орны аюулгүй байдлыг хангах, нийгэм, эдийн засгийн зорилтыг хэрэгжүүлэхэд үр бүтээлтэй ашиглах талаар чармайн ажиллана. | жилдээ | Л.Эрдэнэчулуун |
| | -Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн, 77-гийн бүлгийн үйл ажиллагаанд оролцож, хөгжиж буй орнуудын нийтлэг зорилго болон өөрийн орны үндэсний эрх ашигт нийцсэн асуудлуудаар хамтран ажиллаж, Умард-Өмнөдийн хоорондын яриа хэлэлцээг урагшлуулж, тохиролцоонд хүрэхэд тус дөхөм үзүүлнэ. | жилдээ | Л.Эрдэнэчулуун |
| | -Олон улсын байгууллагын өмнө болон олон улсын гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлнэ. | жилдээ | Л.Эрдэнэчулуун |
| | -Ази, Номхон далайн бүс нутаг, салбар бүсийн хэмжээнд өрнөж байгаа улс төр, аюулгүй байдал, эдийн засгийн олон талт үйл явц болон яриа хэлэлцээнд оролцож идэвхитэй үйл ажиллагаа явуулна. | жилдээ | Л.Эрдэнэчулуун |
| | -Зүүн хойд Ази, Төв Азийн улс төр, эдийн засгийн олон талт үйл явц, яриа хэлэлцээнд идэвхтэй оролцоно. | жилдээ | Л.Эрдэнэчулуун |
| | -Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын олон улсын тавдугаар бага хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | жилдээ | Л.Эрдэнэчулуун |
| | -Химийн зэвсэглэлийг хориглох байгууллагатай хэлэлцээр байгуулах, химийн зэвсгийг хориглох конвенцийн хэрэгжилтийн асуудлаар олон улсын семинар зохион байгуулна. | жилдээ | Л.Эрдэнэчулуун<br>Ж.Гүррагчаа |
| 3.Монгол Улсын иргэдийн эрх ашгийг гадаад орнуудад хамгаалах нөхцөлийг бүрдүүлнэ. | -Монгол Улсын иргэд гадаадад зорчих нөхцөлийг хөнгөвчлөх, хилийн чанадад суралцах, хөдөлмөр эрхлэх нөхцөлд эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд анхаарч ажиллана. | жилдээ | Л.Эрдэнэчулуун |

| | | | |
|---|---|---|---|
| | -Монгол Улсын иргэн, байгууллага болон хуулийн этгээдийн эрх ашгийг хилийн чанадад хамгаалах, шаардлагатай тохиолдолд тэдэнд дэмжлэг үзүүлэх зорилгоор иргэдэд туслах санг хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газруудын дэргэд байгуулах чиглэлээр ажиллана. | жилдээ | Л.Эрдэнэчулуун |
| | -Гадаад орнуудтай хүмүүнлэгийн харилцааг хөгжүүлэхдээ иргэд, төрийн бус байгууллагууд, орон нутгийн захиргаатай нягт хамтран ажиллаж, тэдний үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих асуудлыг анхаарна. | жилдээ | Л.Эрдэнэчулуун |
| | -Гадаад хэргийн яам, Хил хамгаалах Ерөнхий газар, Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв, Гадаадын харьяатын асуудал эрхлэх зөвлөл, Цагдаагийн ерөнхий газар зэрэг байгууллагыг цахим сүлжээнд холбож, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх ажлыг үргэлжлүүлнэ. | жилдээ | Л.Эрдэнэчулуун |
| 4.Улс орныг батлан хамгаалах эрх зүйн орчны шинэчлэлийг гүнзгийрүүлж, орон нутгийн хамгаалалтын удирдлага, бүтэц, зохион байгуулалтын үндсийг бүрдүүлж хэрэгжүүлж эхэлнэ. | -Иргэн цэргийн алба хаахтай холбоотой хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна. | жилдээ | Ж. Гүррагчаа |
| | -Батлан хамгаалах салбарын Шинжлэх ухаан технологийг 2010 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, шинжлэх ухаан технологийн ололтыг батлан хамгаалах салбарт нэвтрүүлэх, эрдэм шинжилгээ, туршилтын ажлыг өргөжүүлнэ. | жилдээ | Ж. Гүррагчаа |
| | -Орон нутгийн хамгаалалтын удирдлага, бүтэц, зохион байгуулалтын үндсийг бүрдүүлж хэрэгжүүлнэ. | жилдээ | Ж. Гүррагчаа |
| | -Агентлаг, сум, дүүргийн дайчилгааны даалгаврыг тогтоон, дайчилгааны төлөвлөгөөг боловсруулна. | жилдээ | Ж. Гүррагчаа холбогдох Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | -Халхын гол дахь дайны 65 жилийн ойг тохиолдуулан 1939 он 1945 оны чөлөөлөх дайнд оролцсон ахмад дайчдад нэг удаагийн мөнгөн тусламж үзүүлнэ. | II-III улирал | Ж. Гүррагчаа |
| | - Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан зориулалт чиг үүргэт нь тодотгол хийх замаар зэвсэгт хүчний стратегийн чиглэлүүдэд зарим анги, салбарыг байгуулах, шилжүүлэх ажлыг зохион байгуулна. | жилдээ | Ж. Гүррагчаа |

| | | | |
|---|---|---|---|
| | -Бие бүрэлдэхүүний бэлтгэлжилтийн түвшинг дээшлүүлж, Зэвсэгт хүчний байлдааны болон тусгай үүрэг гүйцэтгэх боломж чадавхийг нэмэгдүүлнэ. | жилдээ | Ж. Гүррагчаа |
| 5.Цэргийн байгууллалтыг төгөлдөржүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган, Зэвсэгт хүчний байгууллалтыг боловсронгуй болгоход чиглэсэн бодлого, зорилтыг хэрэгжүүлнэ. | -Цэргийн мэргэжлийн удирдлагад мэдээллийн шинэ технологи нэвтрүүлнэ. | жилдээ | Ж. Гүррагчаа |
| | -Зэвсэгт хүчний дайчилгааны материал хэрэгслийн нөөцийг тодотгох, солих, нөхөн хангах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | жилдээ | Ж. Гүррагчаа |
| | -Зэвсэгт хүчний зэвсэг техникийг хэсэгчлэн шинэчлэх ажлыг хэрэгжүүлнэ. | жилдээ | Ж. Гүррагчаа |
| | -Зэвсэглэл, техникийн засвар, үйлдвэрлэл, туршилтын бааз суурийг бий болгох, дотоод нөөц бололцоондоо тулгуурлан зарим жижиг эд анги, сэлбэгийг үйлдвэрлэх техник, технологи, санхүүгийн боломж нөхцөлийг бүрдүүлнэ. | жилдээ | Ж. Гүррагчаа |
| 6.Бүс нутагт аюулгүй байдал, цэргийн итгэлцлийг бэхжүүлэх олон талт үйл явцад идэвхитэй оролцох замаар салбарын гадаад харилцааны хүрээг өргөтгөн, үр өгөөжийг дээшлүүлэх, НҮБ- ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд Монгол Улсын Зэвсэгт хүчний оролцох оролцоог нэмэгдүүлнэ. | -Монгол Улсын аюулгүй байдлыг улс төр-дипломатын аргаар хангах хүрээнд цэрэг-дипломатын идэвхтэй үйл ажиллагаа явуулж, батлан хамгаалах салбарын гадаад харилцааг өргөжүүлнэ. | жилдээ | Ж. Гүррагчаа |
| | -Монгол Улсын Зэвсэгт хүчнийг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлнэ. | жилдээ | Ж. Гүррагчаа |

### ЗУРГАА. ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛ, ЗАСАГЛАЛЫН БЭХЖИЛТ, ХИЛ ХАМГААЛАЛТЫН ХҮРЭЭНД:

| | | | |
|---|---|---|---|
| 1.Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ. | -Монгол Улсын хууль тогтоомжийг 2004 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд тусгагдсан холбогдох хуулийн төслүүдийг боловсруулан УИХ-д өргөн мэдүүлэх ажлыг үргэлжүүлэн зохион байгуулна. | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Эдийн засагт гарч байгаа өөрчлөлтийг үндэслэн Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, хуулийн хэрэгжилтийг хангах, зохицуулах албыг байгуулах арга хэмжээ авна. | жилдээ | Ч.Улаан<br>Ц.Нямдорж |
| | -Яам болон агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийг батлуулж хэрэгжүүлнэ. | I-II улирал | Ц.Нямдорж<br>Ө.Энхтүвшин |
| | -Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд тэдгээрийн бие даасан байдлыг хангах чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулж батлуулан мөрдүүлнэ. | I-II улирал | Ө.Энхтүвшин<br>Ц.Нямдорж |
| | -Үндэсний төв архивын зарим сан хөмрөгийг орчин үеийн зориулалтын нягтруулсан тавиур шүүгээгээр хангах, галын дохиоллын сүлжээг шинэчлэх ажлыг хийнэ. | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Хууль зүйн сургуулийн багшлах боловсон хүчинд тавих нийтлэг шаардлага, хуулийн сургуулиудын орчны стандартыг боловсруулж хэрэгжүүлнэ. | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Хууль зүйн дээд сургуулийн элсэлтийн болон төгсөлтийн улсын шалгалтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх асуудлыг судалж шийдвэрлүүлнэ. | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор тухайн жилийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, цаашид уг ажлыг тогтворжуулна. | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Прокурорын хяналтын ажиллагааны менежментийг боловсронгуй болгох бодлого боловсруулж хэрэгжүүлнэ. | II-IV улирал | Ц.Нямдорж |
| 2.Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам | -Цагдаагийн байгууллагийн автомашины парк шинэчлэх ажлыг үргэлжлүүлэн хийнэ. | жилдээ | Ц.Нямдорж |

| | | | |
|---|---|---|---|
| Сахиулах, урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлнэ. | -Цагдаагийн байгууллага болон алба хаагчдын холбоо, галт зэвсэг, сум тусгай хэрэгслээр хангах ажлыг үргэлжлүүлнэ. | жилдээ | Ц.Нямдорж |
| 3. Хил хамгаалах ажлын техник хангамжийг сайжруулна. | -Буянт-Ухаа, Замын-Үүд, Сүхбаатар, Алтанбулаг дахь хилийн шалган нэвтрүүлэх олон улсын боомтыг харилцан ажиллагаатай байгууллагуудтай мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбох ажлыг дуусгана. | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Хилийн цэргийн удирдлага хооронд болон хилийн цагийн байдлын гэнэтийн өөрчлөлтийн үед нэгэн зэрэг ажиллах удирдлагын холбооны бэлэн байдлыг дээшлүүлж сайжруулах арга хэмжээ авна. | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Уулархаг болон усан хилийн хамгаалалтыг сайжруулах зорилгоор зориулалтын техник хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлнэ. | жилдээ | Ц.Нямдорж |
| 4.Төрийн албаны хариуцлагын тогтолцоог сайжруулна. | -Төрийн байгууллагуудын ажлын зохион байгуулалт, албан хэргийн удирдлагын өнөөгийн байдалд нэгдсэн удирдамжийн дагуу үзлэг хийж холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | I-II улирал | Ө.Энхтүвшин<br>Ц.Нямдорж<br>Ж.Норовсамбуу |
| | -Удирдлагын үйл ажиллагаанд үүсч, хөтлөгдөж байгаа мэдээллийн эрэлт, хайлт, ашиглалтын хөтөлбөр боловсруулж, нэгдсэн сүлжээнд оруулах ажлыг зохион байгуулна. | жилдээ | Ө.Энхтүвшин |
| | -Удирдах албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах журмыг боловсронгуй болгож, авилгалтай тэмцэх гэрээний загварыг батлуулан хэрэгжүүлнэ. | II-III улирал | Ө.Энхтүвшин<br>Ж.Норовсамбуу |
| | -Хяналт шинжилгээ, үнэлгээний чиглэлээр мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх ажлыг зохион байгуулна. | жилдээ | Ө.Энхтүвшин |

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
**Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.**
Улаанбаатар- 12
Төрийн ордон
☎ 329612
Индекс: 14003
Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.
Хэвлэлийн хуудас 6
☎ 329487